

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

## 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРОО

## ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр, Лхагва гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 7
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8 – 50
1.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтоолд өөрчлөлт оруулах тухай/</i>	9 – 10
2.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/</i>	10 – 14
3.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/</i>	15 – 50

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны  
2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 23 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 52.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 01 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Томилолттой: Д.Бум-Очир, П.Ганзориг, С.Лүндэг;  
Чөлөөтэй: Д.Жаргалсайхан, П.Мөнхтулга, Б.Пунсалмаа, М.Энхцэцэг;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Даваасүрэн.*

***Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтоолд өөрчлөлт оруулах тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Г.Баярмаа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга С.Ганбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**С.Ганбаатар:** “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 6  
Бүгд: 13  
53.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 17 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Г.Баярмаа нар байлцав.

“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга С.Ганбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн хариулж, тайлбар хийв.

**С.Ганбаатар:** “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 4

Бүгд: 14

71.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Тулгын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 78.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 17 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны референт

Г.Баярмаа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, С.Замира, Х.Жангабыл, Д.Батбаяр, Д.Пүрэвдаваа, Б.Тулга, Г.Ганбаатар, С.Ганбаатар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа үг хэлэв.

*“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**С.Ганбаатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Тулгын гаргасан, Төслийн 2 дахь дэд заалтын “2028 оны нэгдүгээр улиралд багтааж” гэснийг “ЕРС-4 гэрээнд туссан томъёололтой уялдуулсан гэрээ зурагдсанаас хойш 38 сарын дотор багтааж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 8  
Бүгд: 15  
46.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын гаргасан, Олон улсад нефть боловсруулах үйлдвэрийн төсөлд тавигддаг шаардлагын дагуу эдийн засгийн үр ашиг, техник, технологи, байгаль орчны хувьд боломжтой гэдгийг техник, эдийн засгийн үндэслэлээр баталгаажуулсан байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналын томъёололтой холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Д.Үүрийнтуяа, Г.Очирбат нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 13  
Бүгд: 15  
13.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3. Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын гаргасан, Газрын тос боловсруулах үйлдвэрийн техникийн зураг төсөл, үйлдвэрийг барьж байгуулах зардлын төсөв, барилга угсралтын ажлын график төлөвлөгөөг олон улсын стандартын дагуу үйлдвэрийн барилга, угсралтын ажил эхлэхээс өмнө бүрэн боловсруулж, баталгаажуулсан байх арга хэмжээг авах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 13  
Бүгд: 15  
13.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4. Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын гаргасан, Техникийн зураг төслийн үйлдвэрийн технологийн тоног төхөөрөмж нийлүүлэх, үйлдвэрийг барьж байгуулах төсөв, барилга угсралтын ажлын графикийн дагуу барилгын ерөнхий гүйцэтгэгчтэй үйлдвэрлэлийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх, түлхүүр гардуулах нөхцөлөөр байгуулсан ЕРСС гэрээ хийж баталгаажуулсан байх арга хэмжээг авах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 13  
Бүгд: 15  
13.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

5. Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын гаргасан, Үйлдвэрийг түүхий тос цэвэр, усны нөөцөөр хангах боломжгүй бол хэрхэн шийдэх тухайгаа Улсын Их Хуралд танилцуулах арга хэмжээг авах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналын томъёололтой холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, С.Ганбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 10  
Бүгд: 15  
33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

6. Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 1.1-д “төслийн зардлын хяналтыг сайжруулах зорилгоор Монгол Улсын өндөр түвшний мэргэжлүүдээс бүрдсэн баг томилж, Бүгд Найрамдах Энэтхэг Улс болон бусад улсад хэрэгжиж байгаа зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ажилд хяналт тавьж оролцуулах” гэснийг “төслийн зардлын хяналтыг сайжруулах зорилгоор үндэсний болон олон улсын хараат бус, өндөр түвшний мэргэжилтнүүдээс бүрдсэн баг томилж, төслийн хэрэгжилттэй холбоотой

дотоодод болон хилийн чанад дахь байрлалд хэрэгжүүлж байгаа зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ажилд хяналт тавьж оролцуулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 5

Бүгд: 15

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга Төслийн 2 дахь дэд заалтын “2028 оны нэгдүгээр улиралд багтааж” гэснийг “ЕРС-4 гэрээнд туссан томьёололтой уялдуулсан гэрээ зурагдсанаас хойш 38 сарын дотор багтааж” гэсэн өмнө хураалгасан саналаа хүчингүй болгож, дахиж өөрчлөн найруулсан саналаар санал хураалгая гэсэн горимын санал гаргав.

**С.Ганбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Тулгын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 6

Бүгд: 15

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**С.Ганбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Тулгын гаргасан, Төслийн 2 дахь дэд заалтын “2028 оны нэгдүгээр улиралд” гэснийг “ЕРС-4 гэрээнд зааснаар гарын үсэг зурснаас хойш 38 сарын дотор багтааж” гэж өөрчлөх гэсэн найруулгын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 10

Бүгд: 15

33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**С.Ганбаатар:** “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 6

Бүгд: 15

60.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

*Уг асуудлыг 18 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 53 минут үргэлжилж, 23 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 65.2 хувийн ирцтэйгээр 18 цаг 54 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

С.ГАНБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

---



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр, Лхагва гараг  
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
17 цаг 01 минут

### АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**С.Ганбаатар:** Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаан эхэлж байна.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг би Та бүхэнд танилцуулъя.

Далайн Батбаяр гишүүн ирсэн байна, Сонгобайгийн Замира гишүүн ирсэн байна, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна, Буяагийн Тулга гишүүн ирсэн байна, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ирсэн байна, Жаргалсайханы Золжаргал гишүүн ирсэн байна, Ганбатын Очирбат гишүүн ирсэн байна, Болдын Уянга гишүүн ирсэн байна, Хажекберийн Жангабыл гишүүн ирсэн байна, Ганзоригийн Лувсанжамц гишүүн ирсэн байна, Даваахүү овогтой Пүрэвдаваа гишүүн ирсэн байна, Доржсүрэн овогтой Үүрийнтуяа гишүүн ирсэн байна.

Ингээд нийт гишүүдийн ирц 52.2 хувь хүрсэн учраас өнөөдрийн хуралдааныг эхэлснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хоёрдугаарт нь, Байнгын хорооны тогтоолын төсөл. “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай”.

Гуравдугаарт нь, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл гэсэн ийм гурван хэлэлцэх асуудал байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Гишүүд хэлэлцэх асуудал дээр санал алга байна.

Гишүүдэд бүх материалуудаа тарааж өгөх ёстой шүү. Хэлэлцэх асуудалдаа оръё.

---

### **Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл**

*/Тогтоолд өөрчлөлт оруулах тухай/*

---

Хэлэлцэх асуудал.

Нэг. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар “Тавантолгой түлш” ХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааны талаар шалган судлах холбогдох санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсгийг байгуулсан.

Улсын Их Хурлын гишүүн М.Сарнайгаас дээрх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмж орох саналаа ирүүлсний дагуу тус тогтоолд өөрчлөлт оруулахаар Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулж байна.

Байнгын хорооны тогтоолын төслийг Та бүхэнд уншиж танилцуулъя.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Аж үйлдвэрлэлийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэрлэлийн бодлогын байнгын хорооны 2024 оны ажлын хэсэг байгуулах тухай 02 дугаар тогтоолын 1 дэх заалтад тусгагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд “Улсын Их Хурлын гишүүн М.Сарнай” гэж нэмсүгэй.

Аж үйлдвэрлэлийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар гэсэн ийм тогтоолын төслийг Та бүхэнд танилцуулж байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух, санал гаргах гишүүд нэрээ өгнө үү.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд алга байна.

---

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

---

### **Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл**

*/Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/*

---

Хэлэлцэх асуудал.

Хоёр.“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар Өрхийн бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2025 оны 02 дугаар тогтоолоор байгуулсан.

Өнөөдрийн хуралдаанаар дээрх ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” тогтоолын төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Ингээд Та бүхэнд би тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг үндэслэн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулагдсан Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилт болон Жижиг, дунд үйлдвэрийн хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зээл олголт, эргэн төлөлт, зээлийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах

---

үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн танилцуулга, санал, дүгнэлт, шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 9.8 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж хэлэлцүүлэх, мөн тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч /М.Бадамсүрэн/-нд үүрэг болгосугай.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар гэсэн удирдамж батлах тухай тогтоол байна.

Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух, үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү.

Дамбын Батлут гишүүнээр тасаллаа. Дамбын Батлут гишүүн асуултаа асууна уу.

**Д.Батлут:** Ажлын хэсэг гарсан талаарх мэдээлэлтэй холбоотой удирдамж баталж байгаа юм байна.

Тэгэхээр Улсын Их Хурлын даргын 82 дугаар захирамжаар Жижиг, дунд үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хэсэг гарч ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ хоёр ажлын хэсгийн үүрэг, зорилго нь нэг юм уу, эсвэл өөр өөр чиглэлээр ажиллахаар төлөвлөж байгаа юу? Энэ талаар тодорхой мэдээлэл өгвөл. Нөгөө ижил чиглэлтэй хоёр ажлын хэсэг гарч байна гэж би харах гээд байна л даа.

Тэгэхээр цаашдаа ер нь яах юм бол? Ингээд нэгтгэж явах юм уу? Эсвэл ингээд тус тусдаа явж байгаад асуудлуудаа ярих ёстой юм болов уу? Энэ тал дээр Байнгын хороон даргын хариултыг авъя.

**С.Ганбаатар:** Энэ ажлын хэсгийг бас санаачилсан ахалж байгаа хүн нь хариулах ёстой байх даа. Тийм ээ.

Ямар ч байсан Д.Батлут гишүүний хэлдэг зөв шүү. Д.Батлут гишүүнээр ахлуулсан Улсын Их Хурлын даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг байгаа.

М.Бадамсүрэн гишүүн ороод ирлээ. Энэ асуудал дээр Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн хариулт өгнө.

---

Д.Батлут гишүүнд асуултаа бас дахиж тодруулж асуух боломжийг өгье. Та асуултаа тодруулаад асууна уу? Д.Батлут гишүүний микрофоныг нээж өгье.

**Д.Батлут:** Улсын Их Хурлын даргын 82 дугаар захирамжаар Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хэсэг гараад ажиллаж байна.

Ажлын хэсэг 2 удаа хуралдаад, мэдээллүүдээ сонсоод, одоо хуулийн төсөл нь ерөнхийдөө бараг бэлэн болчихсон. Дээрээс нь орон нутгуудад бас ажиллах тийм хуваарь гараад ажиллаж эхлэх гээд явж байгаа юм.

Тэгэхээр Байнгын хорооноос гаргаж байгаа ажлын хэсэг нь Улсын Их Хурлаас гарсан ажлын хэсэгтэйгээ яг ижил зорилготой явах юм уу?

Мэдээж жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх, тэр дундаа бичил бизнес эрхлэгчидтэй холбоотой асуудлыг тодруулах гээд байгаа, бас санал, дүгнэлт гаргах гээд байна гэдэг чинь өөрөө Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсгийн хийж байгаа ажилтай бараг л нэг ижил зорилго агуулчихсан байна гэж би хараад байна л даа.

Тэгээд үүнийг хэрхэн зохицуулж явах юм бол, яах ёстой юм бол гэдэг талаар нэг тайлбар авмаар байна.

**С.Ганбаатар:** Ажлын хэсгийг санаачилсан, бас өнөөдөр удирдамжаа батлуулж байгаа ажлын хэсгийн ахлагч М.Бадамсүрэн гишүүн энэ дээр тодорхой хариултыг өгнө. М.Бадамсүрэн гишүүний микрофоныг нээж өгье.

**М.Бадамсүрэн:** Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 4 асуудлыг хариуцдаг.

- ▶ Нэгд нь, бүтээмж;
- ▶ Хоёрт нь, хүнд үйлдвэр;
- ▶ Гуравт нь, хөнгөн үйлдвэр;
- ▶ Дөрөвт нь, жижиг, дунд үйлдвэрлэл гээд.

Тийм учраас Байнгын хорооны эрхлэх яг дөрөвхөн асуудлын яг хамгийн чухал ард иргэдэд хэрэгцээтэй энэ хэсэг нь манай дээр ямар нэгэн ажлын хэсэг гараагүй. Энэ асуудал дээр том үйлдвэр гэхээс илүү энэ үйлдвэрлэл рүү бас анхаарах нь зүйтэй гэж олонх гишүүд ярилцаад ингээд 13 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан.

Д.Батлут гишүүний ахалсан ажлын хэсэгтэй бүх талаар хамтран ажиллая гэсэн саналтай байна. Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан байгаа ажлын хэсэг. Манайх бол Байнгын хорооны ажлын хэсэг.

---

Тэгэхээр бидний зорилго чиглэл нэг. Энэ дээр гол нь хууль эрх зүйн орчныг шинэчлэх. Нэг.

Хоёрдугаарт нь, зээлийн эх үүсвэрийг цаашид эрс нэмэгдүүлэх. Тухайлбал, ганцхан тоо баримт хэлэхэд бусад орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүнд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн оруулж байгаа бүтээмж 40 хувь байхад Монгол Улсад 5.5 л хувь байгаа юм. Өөрөөр хэлбэл бараг 7, 8 дахин бага. Тийм ээ.

Тэгэхээр энэ салбарыг явуулъя гэж байгаа. Тэгээд манай мэргэжлийн Байнгын хорооны хувьд энэ зүйл дээр яг Д.Батлут гишүүнтэй адилхан бүх бүс дээр нэг аймгийн төв, нэг сумыг сонгож авч, тэгээд энэ ажлын хэсэгт орсон гишүүдийн оролцоог нэмэгдүүлж ажиллах.

Нийслэлийн төвийн нэг дүүрэг, захын нэг дүүргийг сонгож авч энэ дээр уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, тэгээд хууль эрх зүйн болон сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, зөвлөх үйлчилгээг нэмэгдүүлэх, гадаад зах зээлд холбох, экспортыг дэмжих, уул уурхайн ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгчийг дэмжих зэрэг энэ зүйлүүдийг хийхээр төлөвлөж байгаа.

Тэгээд Д.Батлут гишүүний ахалсан ажлын хэсэгтэй хамтарч ажиллая гэсэн саналтай байна.

**С.Ганбаатар:** Тодруулах уу? Та. Д.Батлут гишүүн тодруулж асууя.

**Д.Батлут:** Тийм.

Тэгэхээр яах вэ, зорилго нэг мөртлөө хоёр ажлын хэсэг байх нь хэр зохистой бол? Зүгээр Байнгын хорооны дарга ч гэсэн эсвэл Их Хурлын даргад санал оруулаад энэ ажлын хэсгийг бүр томоор нь өргөтгөж болох юм. Тэгэх юм бол нэгдсэн зохион байгуулалтаар бүгдээрээ бүх аймаг, орон нутгийн сумууд дээр очиж ажиллах, цаашлаад Монгол Улсын хэмжээнд бичил бизнес эрхлэгчдээ дэмжих боломжийг бүрдүүлэхэд бүс нутгуудын онцлогтой уялдсан томоохон шийдэл гаргахад нэлээн нөлөөлөл үзүүлэх байх гэж би харж байна л даа.

Тэгэхээр яасан нь дээр юм бол? Яах вэ, хамтарч ажиллах нь зөв. Ер нь чиглэл нь зөв. Тэгэхдээ хоёр ажлын хэсэг байх нь зөв юм уу, нэг байх нь зөв юм уу гэдэг дээр нэг шийдэл гаргах уу, яах вэ?

**С.Ганбаатар:** Энэ дээр Дамбын Батлут гишүүний хэлсэн саналыг бид хүндэтгэлтэй хандах ёстой шүү.

---

Энэ дээр миний ойлголтоор нэгдүгээрт ажлын хэсгийг өнгөрсөн хуралдаанаар байгуулсан. Өнөөдөр удирдамжийн тухай ярьж байгаа. Энэ асуудлаар би Их Хурлын даргатай санал солилцоно. М.Бадамсүрэн гишүүнтэй хамт орж уулзана.

Хоёрдугаарт, зүгээр миний байр суурь бол Д.Батлут гишүүний ажлын хэсэг. Би өөрөө тэр ажлын хэсэгт байгаа. Салбар болгонтой. Жижиг, дунд үйлдвэрлэл оролцоогүй салбар гэж байхгүй. Жижиг, дунд үйлдвэрлэлийн асуудал оролцдоггүй. Хөдөлмөрийн яам ч гэсэн хамаатай. Бүр энэ чинь Боловсролын яам ч энд хамаатай.

Тэгэхээр салбаруудын хоорондын уялдааг хангаж бүх Байнгын хороодууд дээр хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуудлуудыг хамж аваад жижиг, дунд үйлдвэрлэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах гэж энэ том макро түвшинд нь Д.Батлут гишүүн ажиллаж байгаа.

Харин М.Бадамсүрэн гишүүний санал бол жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл хууль. Яг одоо энэ Байнгын хорооны түвшинд Хүнс, хөдөө аж ахуйн яаман дээр. Ганцхан яаман дээр харьцаж байгаа шүү дээ.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн бодлого хэрэгжиж байхдаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээр ер нь юу болж байна. Энэ нөгөө зээл нь болж байна уу гэсэн ийм микро түвшинд ажиллаж байна гэж би ойлгож байгаа.

Тэгээд энэ дээр том макро түвшиндээ бүх салбаруудын уялдааг хангаж ажиллаж байгаа Д.Батлут гишүүний ажлын хэсэгтэй. М.Бадамсүрэн гишүүн ээ, маш уялдаж, бид ойлголцож ажиллах ёстой юм байна гэсэн ойлголтыг авлаа. Саяын саналуудыг жич би холбогдох хүмүүстэй нь уулзаж ярих болно.

Ингээд өнөөдрийн энэ удирдамжийн тухай өнөөдөр Та бүхний санал асууж байна.

Ингээд асуулт асууж, саналаа хэллээ.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Б.Тулга сайд дэмжсэн. Протоколд тэмдэглэж оруулаарай.

71.4 хувиар удирдамж батлах тогтоол батлагдлаа.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

---

**Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл**  
/Засгийн газарт чиглэл өгөх тухай/

---

Хэлэлцэх асуудал.

Гурав.Байнгын хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор Монголын газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан.

Тус ажлын хэсгээс боловсруулсан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Тус ажлын хэсгээс боловсруулсан тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Л.Мөнхбаясгалан танилцуулна.

Л.Мөнхбаясгалан гишүүний микрофоныг нээж өгье.

**Л.Мөнхбаясгалан:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороон дээр Монголын газрын тос боловсруулах үйлдвэр дээр хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулагдсан байгаа.

Ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байх явцад Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын ЭКСИМ банкнаас зээл авах асуудлыг соёрхон батлах нь Их Хурал дээр яаралтай горимоор орж ирсэн.

Ажлын хэсэг ажиллаж байгаа. Бид уг нь тайлангаа хаврын чуулганд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж байсан. Асуудал өөрчлөгдсөн.

Тэгэхээр ажлын хэсэг 2, 3 удаа хуралдсан. Уржигдар гэхэд бид Сангийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, тэгээд газрын тос боловсруулах үйлдвэрийнхэнтэй бүтэн 6 цаг хуралдсаны эцэст бид “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын төслийг оруулж ирж байна.

Тогтоолын төслийг уншиж өгөх үү?

**С.Ганбаатар:** Тэгье. Тогтоолын төсөл.

---



**Л.Мөнхбаясгалан:** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.“Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” барих төслийг хэрэгжүүлж, үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-д даалгасугай:

1/Төслийн зардлын хяналтыг сайжруулах зорилгоор Монгол Улсын өндөр түвшний мэргэжилтнүүдээс бүрдсэн баг томилж, Бүгд Найрамдах Энэтхэг Улс болон бусад улсад хэрэгжиж байгаа зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ажилтай харьцуулж дүгнэлт гаргах, хяналт тавьж ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

2/“Монголын газрын тос боловсруулах үйлдвэр”-ийг тухайн жилийн улсын төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх хугацаанд Улсын Их Хуралд тусгайлан танилцуулж, дүгнэлт гаргуулах, бүтээн байгуулалтын ажилд улсын төсвөөс нэмж санхүүжилт гаргахгүй, мөн дотоод, гадаадын зээл авахгүйгээр 2028 оны 1 дүгээр улиралд багтаан ашиглалтад оруулах;

3/ “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр”-ийг барьж ашиглалтад оруулах ажлын төлөвлөгөөг жил бүрээр баталж, төлөвлөгөөний дагуу тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын явц, зээлийн зарцуулалтад хяналт, үнэлгээ хийж, тухайн жилийн улсын төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;

4/Тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт хангалтгүй тохиолдолд холбогдох албан тушаалтанд ажлын хариуцлага тооцож байх;

5/Үйлдвэрт шаардагдах түүхий тосыг дотоодын эх үүсвэрээс бүрэн хангах бодлогыг хэрэгжүүлэх;

6/Төслийн 2020-2024 оны бүтээн байгуулалтын ажилд гүйцэтгэлийн аудит хийлгэж, дүнг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд тайлагнах;

7/Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийн талаар Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд танилцуулах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /С.Ганбаатар/-нд даалгасугай гэсэн ийм тогтоолын төслийг манай ажлын хэсгээс санал болгож Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлж байгаа юм.

Энд тодорхой хэдэн зүйл бий. “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн техник, эдийн засгийн үндэслэлийг нууцад авсан байгаа.

Нууцаас гаргахын тулд заавал Засгийг газрын тогтоол хэрэгтэй. Тэгээд процесс явагдах юм байна.

Дээрээс нь аудитын тайланг бас нууцад авсан байгаа. Аудитын тайланг нууцаас авч танилцах гэж хоёр өдрийг зарцууллаа. Бас л болохгүй байна.

Ер нь энэ үйлдвэр дээр их дутмаг, болж бүтэхгүй зүйл их байгаа. Тэгэхдээ ажлын хэсэг санал, дүгнэлтээ гаргаагүй байгаа. Яагаад гэхээр бид хаврын чуулганд үүнийг танилцуулах ёстой.

Манай гишүүд 4 дэд ажлын хэсэгт хуваагдаад, шалгаад, бүх материалыг татаж үзээд явж байгаа. Тухайлбал, дулааны цахилгаан станц нь гэхэд 50 мегаваттын дулааны цахилгаан станц зүүн бүсэд 81 сая доллароор баригдсан байхад газрын тосны үйлдвэр дээр 35 мегаваттын дулааны цахилгаан станц 189 сая доллароор баригдах тендер нь шалгарчихсан байх жишээний.

Газрын тос боловсруулах үйлдвэрийг 4 багцад хуваасан. 1, 2, 3, 4 гэж багцалж тендер зарласан.

Газрын тос боловсруулах үйлдвэр, тендерийн үнийг буулгах, үнэ бууруулах хэлэлцээрт зөвхөн 4 жил, 2 сараа зарцуулсан байдаг. 50 сарыг.

Багц 4 дээр санхүүгийн эх үүсвэр байхгүй байхад тендер зарласан байдаг. 212 сая доллар дээр “Megha Engineering” гэдэг компани ялалт байгуулчихсан байгаа. Үлдсэн мөнгө нь байхгүй. Тэгсэн хэрнээ 212 сая доллар нь 1.2 тэрбум зээлийн хэлэлцээрт ороогүй, шугам нь нээгдээгүй.

Энэ мэтчилэн багц 4-т дээр мөнгөгүй болсон асуудлууд байдаг. Тухай бүрд нь аудит хийлгээгүй. Ер нь яриад байх юм их байна гишүүд ээ.

Тийм учраас манай ажлын хэсэг 13 Улсын Их Хурлын гишүүнээс бүрдсэн ажлын хэсэг.

Тийм учраас одоо нэгэнт ингээд зээлийн хэлэлцээр яаралтай горимоор ороод ирсэн. Улсын Их Хурал дээр соёрхон батлах ёстой. Бид холбогдох сайдуудтай маш олон удаа уулзсан. Газрын тос боловсруулах үйлдвэрийн ажил гүйцэтгэж байгаа хүмүүстэй маш олон удаа уулзсан. Өчигдөр гэхэд бид нарт 212 хуудас баримт ирүүлсэн. Бүгдийг нь уншиж судалсан. Өнөөдөр Сангийн яамнаас 2016, 2019, одоо 2024 онд соёрхон батлуулах гэж байгаа зээлийн хэлэлцээрүүдийг, мөн тэдний өмнө нь байсан заалтууд, одоо хасагдаж байгаа заалтуудыг харьцуулсан судалгаа ирүүлсэн. Бас танилцсан.

---

Тийм учраас бид зээлийг соёрхон батлах юм бол бид “Засгийн газарт чиглэл өгөх” Байнгын хорооны хурлын тогтоолыг гаргуулж аваад, үүний биелэлтэд хяналт тавьж ажлын хэсэг цаашаа ажиллах ёстой гэдэг үзэл санааг баримталж байгаа учраас Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороогоор тогтоолыг хэлэлцүүлж байгаа юм.

Та бүхэн тэгээд тогтоолын төслийг дэмжиж өгнө үү.

**С.Ганбаатар:** Ажлын хэсгийн ахлагч Л.Мөнхбаясгалан Та бүхэнд мэдээлэл өглөө.

Энэхүү тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асууж, саналаа хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

С.Замира гишүүний нэр орохгүй байна. Б.Тулга гишүүн бас өгсөн байх. Тийм ээ. Б.Тулга гишүүний нэр орохгүй байна. М.Бадамсүрэн гишүүний нэр бас ороогүй байна шүү. Гомбын Ганбаатар гишүүний нэр бас ороогүй байна. Энэ бүхнийг оруулаад.

Ингээд Болдын Уянга гишүүн асуулт асууна.

**Б.Уянга:** Ажлын хэсгийнхэн мэдээллүүдээ нэлээн сайн авч танилцсан юм байна. Манай ажлын хэсэгт Д.Үүрийнтуяа гишүүн байгаа. Тийм ээ?

**С.Ганбаатар:** Байгаа.

**Б.Уянга:** Санхүүгийн зүйлүүдийг нь их сайн харсан байх аа. Танаас л энэ 2 дугаар хэсгийг нь л асуугаадахъя.

Санхүүгийн гүйцэтгэл, явж байгаа ажилтай нь уялдуулаад харахад 2028 оны 1 дүгээр улиралд ер нь ямар нэгэн нэмэлт санхүүжилт авахгүйгээр ашиглалтад орох боломж байна уу?

Хоёрдугаарт нь, өмнө нь байгуулагдсан байгаа 3 гэрээн дээр аваагүй байгаа зээлдээ улсын төсвөөс мөнгө өгөөд байгаа шүү дээ. Тийм ээ?

Тэгэхээр сая өнгөрсөн 3 жилийн хугацаанд Их Хурлын чуулган дээр асууж байснаар 10.1 сая ам долларыг төлсөн гээд тэгж байсан.

Тэгэхээр тэр 3 гэрээ нь хүчин төгөлдөр байгаад байдаг.

Тэгэхээр тэр гэрээнийхээ дагуу үүрэг хүлээгээд, бас төлбөр гарах л байх даа? Яг энэ 2 дугаар заалттай холбоотой үүнийг бүрэн тайлбарлаад өгөөч.

**С.Ганбаатар:** Д.Үүрийнтуяа гишүүн асуултад хариулна.

**Д.Үүрийнтуяа:** Ажлын хэсгийн гишүүний хувьд, тэгээд энэ дотор байгаа санхүүгийн мэргэжлийн ажлыг энэ дэд ажлын хэсэг дээр хариуцаж ажилласан гэдэг агуулаар нь Б.Уянга гишүүнийг асууж байна гэж ойлгож байна.

Түүнээс яг энэ хэлэлцээртэй холбоотой, мөнгө төгрөгтэй холбоотой асуудлыг Б.Жавхлан сайд хариулах нь илүү оновчтой байх. Энэ цаг хугацаанд мөнгө төгрөг нь гарч дуусах эсэхийг.

Энэ ямар агуулгаар ийм заалт орсон бэ гэхээр ажлын хэсэг ажиллаж байх явцдаа бид байгаа материал, баримтын хүрээнд санал, дүгнэлтээ гаргаад, хэлэлцээр чуулганаар орохоос өмнө бид тодорхой түвшинд Засгийн газарт үүрэг чиглэл болгож өгөх нь зүйтэй байна гэж энэ тогтоолын төслийг оруулж ирж байгаа юм.

2028 оны 1 дүгээр улиралд багтааж ашиглалтад оруулах гэдэг нь энэ нөгөө дуусах хугацаандаа уялдуулж л өгч байгаа л чиглэл л дээ. Тэгээд хэлэлцээр дээр 48 сарын хугацаанд зээлээ ашиглаж дуусахгүй бол буцааж татах тухай асуудал байгаа шүү дээ.

Тэгэхээр тэр хугацаанд нь тааруулж дахиж авч байгаа нийт зээлийн дүнг нэмэхгүй байх нь зүйтэй л гэдэг агуулгаар оруулж байгаа болохоос, одоо ямар нэгэн байдлаар дахиж мөнгө гаргах асуудлыг хязгаарлаж байгаа зүйл биш байгаа юм.

Тэгээд яг тэр гүйцэтгэлтэй холбоотой асуудал дээр Б.Жавхлан сайд хариулт өгөх нь илүү зохимжтой байх. Б.Жавхлан сайд нэмэлт тайлбар өгье.

**Б.Жавхлан:** Гишүүддээ оройн мэнд хүргэе. Б.Уянга гишүүний асуултад хариулъя.

Энэ зээлээр санхүүжиж байгаа төсөл дамжуулан төсөл байх ёстой. Одоогоор төсвөөс санхүүжилт огт хийгдээгүй. **ЕРС** [Engineering, Procurement, and Construction]<sup>1</sup> НЭГ дээр Хөгжлийн банкнаас санхүүжилтээ аваад явж байгаа.

2028 оны 1 дүгээр улирал гэж байгаа нь хэрвээ зээл соёрхон батлагдаад ЕРС-4-ийн гэрээ хийснээс хойш 38 сарын дотор гэж байгаа юм. 36-аас 38 сарын дотор.

---

<sup>1</sup> Инженерийн ажил, худалдан авалт, барилгын (ЕРС) гэрээ ([тулхуур гардуулах](#) гэрээний нэг төрөл) нь томоохон, нарийн төвөгтэй дэд бүтцийн төслүүд дээр хувийн хэвшлийн барилгын ажлыг гүйцэтгэхэд ашигладаг гэрээний нэг хэлбэр юм. <sup>[1]</sup> [Тэд Front-End Engineering and Design](#) (FEED) гэрээг дагаж болно.

2 сардаа хэрвээ ЕРС-4-ийн гэрээ хийгдчих юм бол 38 сар гэхээр 2028 оны 4 дүгээр сар болж таарна. Ингээд 2 дугаар улирал руугаа шилжээд орох ийм л зүйл байгаа юм.

Тэгээд зээл соёрхон баталснаас хойш зээлийн ашиглалт гараад явна. Зээлийн ашиглалтыг одоогоор бид төсвийн зардал тал дээрээ 2 мянга.../минут дуусав/

**С.Ганбаатар:** Б.Жавхлан сайдад нэмэлт микрофон дээр үргэлжлүүлж хариулахыг хүсэж байна.

**Б.Жавхлан:** 2025 оны төсөв дээр тодорхой хэмжээнд төсөвлөсөн байгаа. Доор хаяж 350 тэрбум орчим төгрөгийн зээлийн ашиглалтыг гаргах боломжтой байгаа.

Харин 2028 оны 1 байна уу, 2 дугаар улиралд ашиглалтад оруулахын тулд үлдэгдэл 1.4 тэрбум доллар буюу одоогийн ханшаар 4.2 орчим их наяд төгрөг болно. Жилд буухаар 2025, 2026, 2027, 2028 гээд 4 жилийн хугацаанд доор хаяж 1 их наяд гарантай санхүүжилтүүдийг бүрэн хийж байж 2028 онд хугацаандаа ашиглалтад орох санхүүжилтээ бүрэн аваад явна гэж харж байгаа.

**С.Ганбаатар:** Б.Уянга гишүүн тодруулъя.

**Б.Уянга:** Улсын төсвөөс санхүүжилт гараагүй юм байна гэж ойлголоо.

Тэгээд С.Ганбаатар даргын Улсын Их Хурлын гишүүдэд өгсөн албан бичгийн дагуу жаахан даалгавар хийсэн юм. Яг тэнд бичигдсэн байгаа бүх зүйл, заалттай холбоотойгоор хариултуудыг бэлдсэн юм.

Тэгээд яах вэ, холбогдох мэргэжилтнүүдээс асуугаад явахаар нөгөө ЕРС-1, 2, 3 гээд гэрээн дээр Засгийн газраар гэрээ нь байгуулагдсаныхаа дараа нэг нэмэлт гэрээнүүд хийсэн гэж тайлбарлаад байна лээ. Тэр нь ЕРС-1, 2, 3 хугацаандаа хэрвээ ашиглалтад орохгүй бол гүйцэтгэгч компаниасаа өртгийн 5 хувиар ч билүү нэг торгууль тавьж байгаа нэг тийм гэрээ байгуулсан гэж яриад байна лээ. Тэр нь манайд ашигтай л юм шиг сонсогдсон.

Тэгээд ЕРС-4 дээрээ бас тэгээд байгуулчихаар хугацаандаа орох байх гэсэн байдлаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны холбогдох газрын хүмүүс нь хариулж байна лээ.

Тэгэхээр энэ дээр нэг нэмэлт тайлбар хэлээд өгөөч. Яг энэ гэрээнийх нь агуулга нь. Эсвэл тэр газрын тосныхны мэдэж байгаа гэрээ юм болов уу. Үйлдвэрийн.

**С.Ганбаатар:** Ажлын хэсгийн ахлагч Л.Мөнхбаясгалан гишүүн хариулъя.

---

**Л.Мөнхбаясгалан:** Зээлийн дэд гэрээ гэдэг тухайн 4 багц ажил байгаа шүү дээ. Түүн дээр тухай бүр зарласан үнийн дүн нийлээд анх 212 сая доллар байсан. Анх. Одоо жишээ нь 1.2 тэрбумын зээлийн шугам нээгээд, тэндээсээ зарцуулсан нь байхгүй юу.

Тэрийг бид 2023 оны 2 сараас Монгол Улс төлж эхэлсэн юм.

Хэрэглээгүй зээлээсээ 0.5, хэрэглэсэн зээлээсээ 1.75 хувиар хүү төлж эхэлсэн. Тэрийг Сангийн яам ярилцаж байгаад жилд 68 сая доллароор төлөх байсныг 13 сая доллароор төлж байгаа.

Тэр хүүг бид төлөөд явж байгаа шүү дээ. Жилд 20-оод сая доллар байна уу. Тэгж төлөөд явж байгаа.

Тэгэхээр үүнийг та улсын төсвөөс гарсан гэж байгаа. Дэд зээлийн гэрээ гэдэг нь тийм учиртай.

68 сая доллароор төлөх байсныг 13 сая доллароор төлсөн. Энэ нь улсын төсөвт хүндрэл учруулаагүй гэж тайлбарлаж байгаа юм.

Миний бодлоор энэ дахиад 7 жилээр хойшоо сунаж байгаа. Зүгээр зээлийн төлөх мөнгийг л багасгаж, хугацааг нь уртасгаж байгаа юм байхгүй юу. Түүнээс биш нэг их тийм ашигтай юм биш. Хэлэлцээр биш.

Чуулган дээр ярихгүй л байх л даа. Б.Жавхлан сайд хариулах юм уу? Зээлийн дэд гэрээ.

**С.Ганбаатар:** Л.Мөнхбаясгалан гишүүн асуултад хариуллаа. Тодруулж Б.Жавхлан сайд хариулах уу? Нэмэлт тайл тайлбар өгөх үү? Б.Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Би Б.Уянга гишүүнээс асуултыг нь дэлгэрүүлж танаас өөрөөс чинь авъя. Тэгэх үү? Тэгээд би танд хариултаа бэлдэж байгаад шаардлагатай бол микрофон дээр хариулт өгье. Шаардлагатай бол танд би өөрт чинь хариулт өгье. Тийм ээ.

**С.Ганбаатар:** С.Замира гишүүн асуулт асууна.

**С.Замира:** Баярлалаа.

Энэ гэрээ нь 2019 онд хийгдсэн. Тийм ээ. Уг нь өнгөрсөн 30 жилд хийгдсэн гэрээнүүд бүгд алдагдалтай. Монгол оронд. Ихэнх нь. Энэ Оюу Толгой ч байна. Бүгд.

---

Тэгээд яг хөрөнгө оруулалтаар хийх ёстой юмыг ингээд жилээр хийнэ гэдэгт ер нь миний сэтгэлд багтахгүй байгаад байна. Энэ гэрээнүүдийг батлах биш соёрхоно. Харин эргэж харах ёстой юм биш үү. Эргэж хараад үүнийг зээлээр үйлдвэр барина гэхэд. Одоо та ярьж байна. 38 сарын дотор энэ юуг ашиглалтад оруулна гээд. Тэр үед ашиглалтад орох гээд дахиад ингээд суугаад байвал яана аа, хэдүүлээ. Тэгээд хүү төлнө. Дээрээс нь.

Тийм учраас өнгөрсөн 30 жилд хийгдсэн ийм алдагдалтай гэрээнүүдийг уг нь Их Хурал, 126 гишүүнтэй одоогийн парламент дахиад эргэж харах ёстой гэж би бодож байна. Зарчмын зөрүүтэй санал гаргаж байна.

Тийм учраас ажлын хэсэг гараад, тэнд шалгалт хийгээд, Засгийн газарт даалгавар өгөөд. Даалгавар өгөөд өгөөд энэ чинь тэр үед хийгдсэн гэрээгээр явна шүү дээ. Бүх юм чинь.

Тийм учраас энэ бүгдийг нь эргэж харах цаг нь болсон байх гээд бодож байна. Ганц энэ нефтийн гэрээ биш. Бусад гэрээнүүдийг.

Одоо манайх өөрсдөө үйлдвэр бариад байдаг. Тэгсэн мөртлөө түүхий эдийг нь гадаад руу зөөгөөд байдаг. Ер нь энэ бүгд нэг л уялдаж өгөхгүй байна даа. Тэр гадаад руу экспортолж байгаа түүхий эдийг бас эргэж харах ёстой юм болов уу гээд би бодож байна. Үйлдвэр барих юм бол тэрийг зогсох ёстой шүү дээ. Үүнийг л хэлэх гэсэн юм.

**С.Ганбаатар:** С.Замира гишүүний асуулт. Санал хэллээ. Саналыг ажилдаа тусгаж авч ажиллахыг хүсэж байна. Маш чухал, ажил хэрэгч, амьдралд ойрхон маш чухал саналыг манай С.Замира гишүүн хэллээ.

Ингээд Х.Жангабыл гишүүн асуулт асууна.

**Х.Жангабыл:** Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе.

Газрын тосны үйлдвэрийг бид барих нь зүйтэй. Монголын ард түмний хүсэн хүлээж байгаа, мөрөөдөж байгаа үйлдвэр.

Нэлээд ч хугацаа өнгөрчихсөн байна. Гишүүддээ уриалж байна. Ер нь хоёр юмыг ялгаж салгах хэрэгтэй байна. Гадаад, дотоод. Бид гадаад зээл авах асуудлыг яриад байна. Тэгсэн чинь гишүүд дотоодод болж байгаа янз бүрийн асуудлуудыг яриад байгаа. Бид дотооддоо монголчууд зохицож цаашаа ажиллаж болно.

Энэ зээлийг соёрхон батлахгүй бол үйлдвэр эхэлснээс хойш 700 сая доллар салхинд хийсээд алга болох гээд байна. Нэгдүгээрт.



Хоёрдугаарт, олон улсын гэрээ хэлэлцээрийн өмнө хүлээсэн үүргээ Монголчууд биелүүлдэггүй гэсэн муу нэртэй үлдэхээр тийм эрсдэлтэй байна.

Тэгэхээр гишүүдэд энэ зээлийг нь соёрхон батлаад Улсын Их Хурлаар явуулья.

Сая ажлын хэсгийн гаргасан тогтоолын төслийг Байнгын хороогоор батлаад, болзолтойгоор явуулья гэсэн саналтай байна. Дарга аа.

Та тэгээд өөрийнхөө бодлыг өөрчлөөд. Тийм. Гишүүдэд уриалаад, энэ 464 сая долларыг Улсын Их Хурлаар соёрхон батлахад дэмжлэг үзүүлээч ээ гээд уриалж, хүсмээр байна. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Манай Х.Жангабыл гишүүн маш чухал санал хэллээ.

Асуулт байсан уу? Сая. Санал байсан. Тийм ээ. Бас ажлын хэсгийн гишүүн шүү дээ. Тийм. Санал хэллээ.

Ингээд Далайн Батбаяр гишүүн асуулт асууж, саналаа хэлнэ.

**Д.Батбаяр:** Та бүхэнд энэ үдшийн мэндийг хүргэе.

Тэгээд ажлын хэсэгт орж ажиллаж байгаа. Сүүлийн хэдэн хоног ажлын хэсэг нэлээн нухацтай ажиллаж, энэ “Монгол газрын тосны үйлдвэр” гэдэг компанийн удирдлагуудтай уулзаж мэдээлэл авах уулзалтуудыг хийсэн.

Тэгээд уулзалтын дараа ажлын хэсэг хуралдаад “Засгийн газарт чиглэл өгөх” тогтоолын төслийг Байнгын хороогоор гаргуулья гэдэг саналыг гаргасан.

Ер нь хүн болгон ойлгож байгаа. Монгол газрын тос боловсруулах үндэсний үйлдвэр байх учиртай. Монгол Улсын эрх ашигт хамгийн ихээр нөлөөлж байгаа юм. Газрын тос шатах шатахууны материалыг үйлдвэрлэдэг үйлдвэр Монгол Улсад заавал байх ёстой.

Тэгээд төсөл болгоныг санхүүжүүлэх мөнгө нь хэр болгон олддоггүй. Улс төр ордог, элдэв янзын асуудал ордог учраас.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн хувьд санхүүгийн асуудал нь шийдэгдчихсэн учраас үүнийг цааш нь явуулах ёстой гэдэг хувь гишүүний хувьд ийм саналтай байгаа. Гэхдээ асуудлууд байна.

Сүүлийн хэдэн хоногийн турш ажлын хэсгийн шугамаар төслийг хэрэгжүүлж байгаа компанийн төлөөллүүдтэй уулзсан, удирдлагуудтай уулзсан. Ажлын хэсэг. Хангалттай хариултаа авч чадаагүй. Өчнөөн асуудлууд байна гэж харсан.

---



Гэрээ байгуулагдсан 2019 оноос хойш 5 жилийн хугацаанд хийгдсэн ажлуудыг хангалтгүй байна гэж харсан. Мөн энэ төсөлтэй холбоотой ТЭЗҮ, 2020 оны аудитын тайлангууд улсын нууцад орсон. Танилцах боломжгүй, олон нийтэд дэлгэгдэх боломжгүй болсон нөхцөл байдлууд байна гэж харж байгаа.

Энэ төсөл чухал учраас, энэ төсөл заавал хэрэгжих ёстой учраас бид хариуцлага тооцдог, бүх юм ил байдаг, шилэн байдаг ийм зарчмаар явах ёстой. Ингэж байж энэ төсөл хэрэгжинэ, ингэж байж бид үйлдвэртэй болно гэж харж байгаа.

Тийм ч учраас одоогийн нөхцөл байдалд тааруулаад ажлын хэсгээс тогтоолын төслийг санал болгосон. Энэ тогтоолоор Засгийн газарт чиглэл өгөх замаар бид хариуцлагын тогтолцоогоо хэрэгжүүлэх юм байна, хяналт тавьж чадах юм байна. Ингэснээр энэ үйлдвэр ашиглалтад орох юм байна гэсэн ийм дүгнэлтэд хүрсэн юм.

Тэгэхээр Байнгын хороодын гишүүд Та бүхнийг энэ тогтоолын төслийг дэмжиж өгөөрэй гэж хүсэх гэсэн нэг хүсэлт байна.

Хоёрдугаарт нь, Сангийн сайд Б.Жавхлангаас бас асуух асуулт байна. Юу вэ гэхээр 2022 оноос хойш ЕРС-4 буюу хамгийн сүүлийн төслийг хэрэгжүүлэх санхүү, зээлийн асуудлыг ярьж эхэлсэн байгаа. Тэгээд энэ зээл шийдэгдээд гэрээ эхний шатанд гарын үсэг зурагдсан.

Тэгэхээр гэрээ нь.../минут дуусав/

**С.Ганбаатар:** Далайн Батбаяр гишүүн 1 минут нэмж тодруулъя.

**Д.Батбаяр:** Тэгэхээр урьдчилсан байдлаар гэрээнд гарын үсэг зурсан учраас Улсын Их Хуралд орж соёрхон батлах асуудал үүсэж байгаа.

Тийм учраас гэрээгээр буюу нэмэлт санхүүжилтийн гэрээгээр ямар ямар асуудлууд, зөвхөн санхүүжилтээс гадна өөр ямар нэгэн асуудлууд орж ирж байгаа юу?

2019 онд анх зурагдсан энэ гэрээнээс зарчмын хувьд ялгаатай өөрчлөлттэй заалтууд байгаа юу гэсэн ийм асуулт байна. Яагаад гэхээр тодорхойлж баталж асууя гэж бодож байгаа.

Энэ төсөл хэрэгжүүлж байгаа байгууллага маань өөрөө в хэрхэн тендерээ явуулж байгаа, сонгон шалгаруулалтаа хэрхэн явуулж байгаа нь тодорхойгүй байгаа учраас гэрээг зурсан ажлын хэсгээс тодруулж асууя гэж бодсон.

Мөн түүнчлэн энэхүү гэрээгээр Энэтхэг Улсын хуулиар хэрэгжинэ, Энэтхэг улсын аудитаар элдэв маргааныг шийднэ гэсэн.../минут дуусав/

**С.Ганбаатар:** Б.Жавхлан сайд асуултад хариулья.

**Б.Жавхлан:** Д.Батбаяр гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр энэ удаа орж ирж байгаа Энэтхэг Улсын Засгийг газрын 100 хувийн ЭКСИМ банкнаас төслийн үлдэгдэл санхүүжилтийг санхүүжүүлэхээр гэрээ соёрхон батлуулахаар төсөл орж ирж байгаа гэсэн үг.

Тэгэхээр зөвхөн санхүүжилтийн асуудалд л хөндөгдөнө. Түүнээс биш үйлдвэрийн технологи болон тэр бусад тендертэй холбоотой асуудлууд огт байхгүй.

Энэ бол нэмэлт гэрээ. Өөрөөр хэлбэл өмнөх 2018, 2019 онд хоёр ч удаа Улсын Их Хурлаар соёрхон баталсан гэрээний үндсэн нөхцөлүүд яг хэвээрээ. Хэмжээ, хугацааны хувьд л өөр. Нэмэгдэж орж ирж байгаа гэсэн үг.

Зээл, тусламжийн хувьд хоёр төрлийн зээл авдаг. Д.Батбаяр гишүүн ээ. Олон талт хөгжлийн институцүүд буюу Азийн хөгжлийн банк, Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан гээд. Эдгээр байгууллагуудаас бид нэлээдгүй хөнгөлөлттэй. Яагаад гэвэл бид тэр цаад институцийнхээ гишүүн орон. Өөрөөр хэлбэл эзэн орон нь байхгүй юу.

Тийм учраас гишүүн орнуудтай харьцангуй хөнгөлөлттэй нөхцөлөөр. Цаад талын ямар нэг тулгалт, юу байхгүйгээр ийм илүү таатай нөхцөлүүд орж ирдэг.

Ийм хоёр талт хөгжлийн институтүүдээс орж ирж байгаа зээлүүд дээр харьцангуй цаад улсынхаа экспорт, цаад улсынхаа бодлогыг дэмжсэн нөхцөлүүд орж ирдэг. Энэ 30 жилийн хугацаанд бид хоёр талт олон улсын институтүүдээс авсан маш их зээл, тусламжууд байгаа. Тэр болгон дээр эдгээр зүйлүүд орж ирдэг.

Энэ удаагийн гэрээн дээр ч гэсэн тийм зүйлүүд байгаа. Хэрвээ янз бүрийн маргаантай асуудал гарах юм цаад зээлдүүлэгч улсынхаа дүрмээр явна, хуулиар явна гэдэг энэ заалтууд яг ижил форматаар орж ирдэг. Түүгээрээ орж ирж байх жишээтэй.

Дээрээс нь, Энэтхэгийн тал энэ удаа юуг хатуу анхааруулсан бэ гэхээр гурав дахь удаагаа зээл орж ирж байгаа учраас дахиж зээл байхгүй шүү. Дахиж зээл байхгүй. Дахиж үнийн өсөлт юм уу, хугацаа алдсанаас болж эрсдэл үүсэх юм бол Монголын тал дангаараа өөрсдөө хариуцаарай.

Ингээд намрын чуулган дээрээ соёрхон батлагдаад 2 сардаа багтаагаад ЕРС-4-ийн гэрээ хийгдээд 38 сарын дараа ашиглалтад ороод, тэндээс хойш төсөл өөрөө өөрийгөө санхүүжүүлээд, төсөл өөрөө зээлээ төлөөд явах юм байна гэдэг ийм нөхцөлүүдтэйгээр гэрээ хийгдэж байгаа гэсэн үг. Тийм.

**С.Ганбаатар:** Далайн Батбаяр гишүүн тодруулъя.

**Д.Батбаяр:** Баярлалаа.

Тэгэхээр өнөөдрийн Байнгын хорооныхоо хурлаар бид бүгдээрээ тогтоолынхоо төслийг ер нь дэмжээд явсан нь дээр. Ингэснээрээ үйл ажиллагаагаа явуулж байгаа энэ компанид тодорхой хэмжээгээр бид хяналтаа тавих боломж нь бүрдэх юм.

Тэгэхээр Та бүхнээс дахин хүсье. Энэ тогтоолынхоо төслийг бүгдээрээ батлаад явъя.

Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр байгуулагдсан ажлын хэсэг яг үүнээс хойш төслийн хэрэгжилттэй холбоотой хяналт шалгалтаа хийгээд явъя. Хажууд нь өнөөдөр орж ирж байгаа энэ гэрээ нь батлагдаад, санхүүжилтийн асуудал нь тусдаа яваад Улсын Их Хурлаараа соёрхон батлагдаад явах байх гэж бодож байна. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Далайн Батбаяр гишүүн санал хэллээ. Д.Пүрэвдаваа гишүүн асуулт асууя.

**Д.Пүрэвдаваа:** Оройн мэнд.

Нэг зүйлийг тодруулж хэлж байгаад асуултаа асууя гэж бодож байна.

Юу вэ гэхээр Монгол Улс ямар ч байсан өөрийн гэсэн газрын тосны үйлдвэртэй байх нь зүйтэй юу, зүйтэй. Хятад Улс, Орос Улс хил хаалаа, ковид боллоо гэхэд өөрийн гэсэн эх үүсвэртэй, түүндээ таарсан санхүүгийн хувьд бөгөөд эдийн засгийн хувьд үр өгөөжтэй газрын тосны үйлдвэртэй байх гэдэг дээр 100 хувь санал нийлж байгаа.

Гэхдээ өнөөдөр ТЭЗҮ нь нууц. Нууцын байдалтай. Аудит нь нууц. Санхүүгийн бөгөөд эдийн засгийн өгөөж нь тодорхойгүй. Урьд өмнө нь яг үүнтэй ижил төсөөтэй үйлдвэр Монгол Улс, мөн гадаад улсад баригдаж байсан үйл ажиллагаа нь өгөөжөө өгч байгаа үйлдвэрлэлийн. Энэтхэгийн нөхдүүд барьж байна шүү дээ. Хаана барьчихсан юм? Ямар ч тодорхой мэдээлэлгүй байхад нэмэлт санхүүжилтийн асуудлыг ярих боломжгүй юм.

Тийм учраас би С.Ганбаатар гишүүн, С.Замира гишүүнтэй санал нэг байна. Үүнийг татах хэрэгтэй. Хойшлуулах хэрэгтэй.

---

Би тэгээд Сангийн сайд болон ажлын хэсгийн даргаас ганц нэгхэн зүйлийг асуумаар байна.

2024 онд “Дачин Тамсаг” нийт түүхий тосноос миний ойлгосноос 300 орчим тэрбум төгрөгийн орлого улсын төсөвт оруулсан. Бүтээгдэхүүн хуваах гэрээнийхээ дагуу бид далан хэдэн хувийг нь, түүхий тосоо энэ үйлдвэр ашиглалтад орлоо гэж бодоход Монгол Улс жил болгон хэдэн төгрөгийн төсөвт тавьж тэрийг худалдаж авах вэ? Бид 24 хувиа л үнэгүй авна шүү дээ. Нэг.

Хоёрдугаарт, тунгалаг бүтээгдэхүүний гарц хэдэн хувьтай байгаа юм? Өнөөдөр газрын тосны үйлдвэр 1 сая 300 мянган тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ гэсэн. Тэгэхэд түүхий нефтийн хэмжээ хэд байх ёстой юм? Энэ дутсан зөрүүг Оросын Холбооны Улсаас авах юм уу, Хятадаас авах юм уу? Үйлдвэр хэдэн хувийнхаа хүчин чадлаар ажиллах юм бэ?

Манай хэрэглээ 2.8 сая. Манай үйлдвэр хэрвээ өнөөгийнхөөрөө 500 мянган тонн түүхий нефть олборлож байх юм бол 50 хувиар тооцоход. Энэ тэгэхдээ дэлхийд байхгүй жишиг шүү. Тэгэхэд 250 мянган тонн л хэрэглээнийхээ 10 хувийг хүрэхгүйг л үйлдвэрлэнэ. Энэ санхүүгийн өгөөжгүй үйлдвэрийг яг энэ мөчид бүх юмаа нууцалж байгаад хамгаалж гарах нь хэний эрх ашиг юм? Өнөөдөр Монгол Улсад ашигтай юу? Ямар параметруудээр үүнийг ашигтай гэж хараад байгаа юм бэ?

Тэгээд гарах шингэн бүтээгдэхүүн буюу шатахууны үнийг мэдмээр байна. Баярлалаа. Тэгээд тодруулна.

**С.Ганбаатар:** Д.Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Сангийн сайд Б.Жавхлан.

**Б.Жавхлан:** Д.Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя.

Энэ удаа Засгийн газар зээл соёрхон батлуулахаар төсөл оруулж ирсэн байгаа.

Үйлдвэрийн технологитой холбоотой, ялангуяа тэр түүхий эд нийлүүлэлттэй холбоотой асуудлуудыг чиглэлийн яам нь байж байгаад хариулбал зүгээр байх. Би буруу, зөрүү юм ярьчихвал дэмий.

Харин миний хариулж чадах нэг зүйл байна. Үйлдвэр ашиглалтад орсноос хойш, одоо ч тэр төсвөөс хөрөнгө гарч түүхий эд худалдаж авах асуудал байхгүй. Ашиглалтад ормогц цаашаагаа үйлдвэр өөрөө зээлээ төлнө, үйлдвэр өөрөө түүхий эдээ худалдаад аваад явах байгаа юм. Түүнээс биш төсвөөс мөнгө гарч түүхий эд худалдаж авах асуудал огт байж болохгүй. Энэ дээр би тантай санал нийлж байна.

Тийм учраас үүнийг би тодорхой хариулж чадахаар байна.

Яах вэ, үйлдвэрлэлийг нууцлах юу байх вэ. Энэ маань өөрөө 2017 онд эхэлсэн төсөл. Одоо үргэлжлэх санхүүжилтийг ярьж байгаа асуудал. Түүнээс биш гараанаас нь гаргах гэж байгаа зүйл огтоос биш. Өмнө нь хоёр ч удаа зээлийг нь соёрхон батлах хэлэлцээр Улсын Их Хурлаар орж батлагдаад, Улсын Их Хурлаар энэ төслийг эхлүүлэх, гараанаас нь гаргах бүх шийдвэрүүд нь гараад өнөөдрийнхөө түвшинд хүрээд дараагийнхаа нэмэлт санхүүжилтийг шийдүүлэхээр явж байна гэсэн үг. Тийм.

**С.Ганбаатар:** Д.Пүрэвдаваа гишүүний асуулттай холбогдуулаад Уул уурхайн яамны сайд, холбогдох газар, хэлтсийн дарга нар, яг энэ үйлдвэрийн асуудал хариуцаж байгаа хүмүүсийг нь бүгдийг нь дуудаарай.

Өнөөдөр Монголын ард түмэнд 2.2 тэрбум доллар. Цаашдаа 3, 4 тэрбум доллар болж болзошгүй ийм их мөнгө, хувь заяаны тухай ярьж байгаа учраас тэр холбогдох хүмүүсийг нь дуудаарай.

Д.Пүрэвдаваа гишүүн тодруулъя.

**Д.Пүрэвдаваа:** Бас нэг зүйлийг мартсан байна.

“Дачин Тамсаг” компани 360 орчим байна уу, 370 орчим тэрбум төгрөгийн өртэй. Татварын болон нийгмийн даатгал гэх мэт холбогдох нэмэлт өртэй байгаа.

Үүнийг шүүхээр шийдвэр нь гарсан юм уу? Нефть, түүхий тосоо гаргахын тулд “Дачин Тамсаг” компанийн үйл ажиллагааг дэмжихийн тулд шүүхээр шийдэгдсэн өр зээлийг хэрхэн дарах гэж байгаа талаар Сангийн яамнаас асуумаар байна. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Б.Жавхлан сайд хариулт өгье.

**Б.Жавхлан:** Д.Пүрэвдаваа гишүүний асуултад нэмж мэдээлэл өгье.

Төслийг хариуцсан ажиллаж байгаа “Петрочайна” компанид татварын асуудал байгаа. Татварын маргаантай асуудал байгаа. Энэ бол татварын маргаан таслах зөвлөл дээр асуудал нь удаа дараа ороод шийдэгдсэн.

Одоо бидний баримталж байгаа Татварын хууль, дүрэм журмын дагуу акт тогтоосон. Эргэн төлүүлэх ажиллагаа хийгдэж байгаа гэсэн үг. Тийм.

Чөлөөлнө гэж байхгүй. Одоо байгаа хууль, дүрмийнхээ хүрээнд тийм асуудал байхгүй. Оюу Толгой дээр ч байхгүй.

---

**С.Ганбаатар:** Асуултад хариулт авлаа. Б.Тулга гишүүн асуулт асууя.

**Б.Тулга:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг эрье.

Байнгын хорооноос ажлын хэсэг гараад ийм чиглэлээр аятайхан тогтоол боловсруулаад орж ирж байгааг дэмжиж байна. Түрүүн Д.Батбаяр гишүүн гээд гишүүд хэллээ. Монгол Улс энэ боловсруулах үйлдвэрээ өөрсдөө барих нь зөв.

Гэхдээ энэ дээр олон нийт зөв мэдээлэлтэй байж, ялангуяа ажлын хэсэг, манай Байнгын хороо, цаашлаад Улсын Их Хуралд мэдээлэлтэй байж хяналтаа зөв тавих энэ механизм байх нь чухал юм гэдэг дээр санал нэг байна.

Ер нь саваа бэлдэхээс саалиа бэлд гэж үг байдаг.

Тийм учраас бид одоогоор хэдийгээр газрын тос шууд юу гэдэг юм бэлэн гарчихсан, энд нийлүүлэх юу байхгүй байна гэж ярьж байгаа ч гэсэн бас ирээдүйд гарах юуг тавина гэдэг ийм бодолтой байна.

Зүгээр жишээ ярихад Казахстан Улс улс болчхоод нийслэлээ шилжүүлж байхад хөрөнгө мөнгө байгаагүй. Тэр үед зориглоод нийслэлээ шилжүүлэх шийдвэрийг гаргаад, үүнийг дагаад газрын тос үүний дараахан олдож байсан, нээж байсан. Зориглоод хөдлөөд явах юм бол аливаа асуудал шийдэгддэг.

Тэгэхээр нэгэнт эхлээд явчихсан, 2017 оноос хойш явж байгаа энэ төслийг зогсоохгүй. Улсын Их Хурал ялангуяа энэ 4 жилийн хугацаанд ингэж эвслийн Засгийн газар байгуулж явж байгаа үед хяналт шалгалтаа тавиад цаг хугацаанд нь оруулах нь бидний үүрэг байх.

Тэгээд энэ чиглэл өгөх тухай тогтоолын төсөл дээр нэг санал байна. С.Ганбаатар дарга аа, гэрээн дээр сая Б.Жавхлан сайд бас дурдах шиг боллоо. ЕРС-4 гэрээ зурагдсанаас хойш 38 сарын дараа гэж гэрээний төсөл дээрээ яваа юм байна.

Тэгэхээр хэдүүлээ зээл авахгүйгээр тэр улиралдаа багтаан ашиглалтад оруулах гэдгийг жоохон найруулаад. Ялгаагүй л 3, 4 сар, 1 сар, 2 сарын зөрүү гарах юм шиг байна. Зээлийн гэрээ ЕРС-4 зурагдсанаас хойш 38 сарын дараа гэдгээр нь оруулаад өгчихвөл бас зүгээр юм болов уу гэсэн санал оруулж байна. Тэгээд үүнийг гишүүд дэмжиж өгнө байх гэдэгт найдаж байна. 38 сарын дотор байхгүй юу.

Тэгэхээр түүгээр нь тавиад өгчихье гэсэн санал байна. Тийм. 2 дугаар заалт дээр. Одоо амжилттай 2 сард багтаад зурчихвал ер нь бараг таарах юм билээ. Гэрээнд нь суулгачихъя. Тэгвэл янз янзын маргаан сүүлд нь гарахгүй амар юм болов уу л гэж бодож байна. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Б.Тулга сайд санал гаргалаа. Зарчмын санал гаргалаа. Саналаа та нөгөө саналын томъёолол дээр бичээд хураалгачихвал бүр амар шүү. Тийм. Энэ дээр одоо ингээд хураалгачхаарай.

М.Бадамсүрэн гишүүн асуулт асууна. М.Бадамсүрэн гишүүн хажууд нөгөө утааны сонсгол хийгээд. Гишүүд давхардаад байгаа шүү.

Ингээд Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

**Г.Ганбаатар:** Сүүлийн үед үнэхээр энэ газрын тосны үйлдвэрийн асуудал Их Хурлын түвшинд их л яригдаж байна.

Ер нь “авч явахад тээртэй, хаяхад гарзтай чемодан” гээд нэг үг байдаг. Түүн шиг л юм болчихлоо шүү дээ. Ний нуугүй хэлэхэд. Одоо цаашаа явахад их хүндрэлтэй юм үнэхээрийн гарахаар юмнууд их байна.

Уг нь одоо энэ чинь жилийн 1.75 хувийн хүүтэй, 20 жилийн хугацаатай, үндсэн төлөлтөөсөө 5 жил чөлөөлсөн ийм сайхан эх үүсвэрийг Ч.Сайханбилэг сайд байхдаа 2015 онд гэрээнд гарын үсэг зураад, 2017 онд тэр үеийн Засгийн газар зоригтой эхлүүлсэн нь сайн хэрэг боловч яг хэрэгжилтийнхээ 8 жилийн дараа бид дөнгөж гүйцэтгэл нь 21-хэн хувьтай.

Дээрээс нь ахиад анхныхаа төсөвт өртгөөс 1 тэрбум. Энэ чинь анхных нь ТЭЗҮ нь 1.2 тэрбум байсан. Одоо 2.2 тэрбум долларын асуудал ярьж байна шүү дээ.

Тэгээд цаашдаа ахиад хэдэн тэрбумаар нэмэгдэх юм. Үнэхээрийн мэдэхгүй. 36 сардаа багтаж ороосой гэж залбирч байгаа. Монгол хүн болгон, Их Хурлын гишүүд болгон л нэг ийм үндэсний үйлдвэртэй болох юм сан гэж бодож байгаа.

Гурван алдаа л гарсан юм шиг санагдаж байгаа юм.

Эхлээд асуултаа асуучихъя. Чуулган дээр гуравхан минут асуухаар зарим үед багтахгүй. Тэгээд хариулж байгаа нөхдүүд дэндүү хайнга хариулах юм.

Би Баасан гарагийн чуулган дээр манайх ашиглагдаагүй зээлийнхээ хүүд 0.5. Тэр олон улсын жишиг ч яах вэ 0.5-аар төлж л байгаа байх. Тэр **COMMITMENT FEE**<sup>2</sup> дээр 0.5. Одоо өнгөрсөн хугацаанд чинь бид 10.1 сая доллар төлчхөөд байна шүү дээ.

---

<sup>2</sup> Ашиглагдаагүй зээл. Ирээдүйн тодорхой хугацаанд амласан зээлийн төлөө банк зээлдэгчдээсээ авдаг шимтгэл.



Хэрвээ бид ашиглагдаагүй зээлийнхээ гэрээнд төлж байгаа бол хугацаандаа гүйцэтгэлээ оруулаагүй Энэтхэгийн талд гэрээний үүргийн биелэлт гэж юу байгаа юм бэ гэж асуухаар хариулаагүй.

Энэ талд гэрээний үүргийн биелэлттэй холбоотой. 36 сарын дараа орохгүй бол Энэтхэгийн тал ямар хариуцлага үүрэх юм бэ гэдгийг одоо Б.Жавхлан сайдаас асууя.

Хоёр дахь зүйл нь. Энэ “НОРИНКО” компаниар 338.0 сая доллароор 530 километр хоолойг бариулсан юм байна л даа. Уг нь энэ чинь анх төмөр зам гэж байсан юм. Энэ хугацаандаа бас төмөр замаа татаад авъя гэж байсан.

Одоо 338.0 сая доллар дээр чинь нэмээд ахиад газрын тос өтгөн үед дамжуулах насос нь энэ юундаа орсон байх. Эрчим хүчний зардал гарах уу? Энэ шугам хоолойнуудыг дагаад эрчим хүч, тэр насосуудыг дагаад эрчим хүч байгаа байх. Энэ бас халаах. Шугам хоолой чинь халаах шаардлага гардаг шиг санаж байна. Өвлийн улиралд. Тэгвэл тэр эрчим хүчний зардал, түүнтэй холбогдох зардал нэмж гарах уу? 338.0 сая доллар дээр.

36 сарынхаа дотор хэрвээ бид энэ үйлдвэрээ зүгээр муугаар бодож байна л даа. Одоо сүүлдээ ч. Ашиглалтад оруулж чадахгүй бол манайхаас ямар үүргийн биелэлт байгаа вэ? /минут дуусав/

**С.Ганбаатар:** Г.Ганбаатар гишүүнд 1 минут нэмж өгье.

**Г.Ганбаатар:** Гурав дахь асуулт нь, түүхий эдийн нөөц байгаа юм.

Яг үнэндээ би чинь өөрөө Дорноговийн хүн. Энэ Алтанширээд яагаад анх сонгочихсон юм гэж бодоод байдаг юм. Тэр түүхий эдийнхээ нөөцтэй газар нэгдүгээрт яагаад Дорнодод хийгээгүй юм бол?

Хоёрдугаарт, Алтанширээд “Голденси” гэж компани нь жаал хайгуул хийж байгаад юм олоогүй юм л даа. Тэгээд хуурай газар хуурай худаг шиг л юм ухаад байгаа юм. Түүхий эдийн нөөцөө ер нь.

Түрүүн Д.Пүрэвдаваа гишүүн бас асуугаад байгаа харагдана лээ. Яг бүрэн хүчин чадалтай ашиглахад яаж шийдэгдэх юм бэ гэдэг ийм асуулт байгаа юм.

Тэгээд энэ дээр дараа нь саналаа хэлчихье. Гурван санал байгаа.

**С.Ганбаатар:** Б.Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Г.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

---



Хэрвээ хугацаандаа ашиглалтад орохгүй болбол шалтгаан нь Монголын талаас л баймааргүй байгаа юм. Өөрөөр хэлбэл бид зээл аваад, түүнийгээ хугацаанд нь гаргаж өгч чадаагүй, санхүүжилтээ хийгээгүй, хоцроосон, тэр шалтгаан нь төсөв дээрээ тавиагүй ч гэдэг юм уу. Хэдүүлээ өөрсдөө асуудалд орохгүйгээр бүрэн санхүүжилтээ хийчхээд дараа нь хугацаагаа нэхэх нь бидний хувьд чухал байгаа.

Хэрвээ хугацаандаа ашиглалтад оруулахгүй болбол мөнгө нь бидэнд байгаа юм чинь бид санхүүжилттэй нь л ярина. Тийм. Санхүүжилттэй нь л ярина гэсэн үг. Энэтхэгийн тал мэдээж энэ дээрээ хариуцлага хүлээж таарна.

Тэр хоолойны эрчим хүчний технологийн асуудлуудыг бид хариулахаас илүү чиглэлийн яам хариулах нь зөв байх. Энэ нарийн юмнуудыг бид яаж мэдэх вэ дээ.

Өнөөдөр Байнгын хороон дээр би санаачилгаар гүйгээд ороод ирсэн шүү. Ажлын хэсгээс ийм төсөл танилцуулах гэж байна гэхээр.

Яагаад вэ гэхээр энэ төслийг миний хувьд дэмжиж байгаа. Засгийг газрын зүгээс, Сангийн яамны зүгээс, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны зүгээс энэ тогтоолын заалт бүртэй хамтарч ажиллахад бид бэлэн байна гэдгийгээ илэрхийлэх гэж орж ирсэн юм. Тийм.

**С.Ганбаатар:** Гомбын Ганбаатар гишүүн тодруулъя.

**Г.Ганбаатар:** Аж үйлдвэржилтийн байнгын хорооныхондоо баярлалаа.

Би яах вэ саналын эрхгүй гишүүн. Энд орон нутгаас нь сонгогдсон гишүүний хувьд санаа зовж, дээрээс нь Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн байнгын хорооноос Засгийн газарт чиглэл өгч байгаа үед нь өөрийнхөө байр суурийг илэрхийлж саналаа хэлье гээд ороод ирсэн байгаа юм.

Тэгээд энэ дээр ер нь ийм юм байгаа шүү. Энэ төсөл чинь 3 гол зүйл дээр л алдчихсан юм шиг харагдаад байгаа юм.

Нэгдүгээрт нь, бид санхүүжилтийг олж ирсэн мөртлөө

- санхүүжилт нь,
- гүйцэтгэл нь,
- явцын хяналт гурав нь нэг сагсанд орчихсон байна.

Тийм учраас “мөнгөө хэн төлсөн нь хөгжмөө захиалдаг” гэдэг шиг хэтэрхий эрх мэдэл, давуу тал Энэтхэгийн талд гарчхаад байна шүү гэдэг.

---

Тэгээд тогтоолын төслийн 1 дээр тэр төслийн зардлын хяналтыг сайжруулах зорилгоор Монгол Улсын өндөр түвшний мэргэжилтнүүдээс бүрдсэн баг гээд байна шүү дээ. Үүнийгээ бас олон улсын баг давхар оруулчихвал зүгээр юм уу гэсэн ийм санал байгаа.

**С.Ганбаатар:** Гомбын Ганбаатар гишүүний тэр олон улсын шинжээч, экспертүүд гэж. “Бие даасан” гэдэг нэг үг нэмчихмээр байна. Энэ их чухал санал шүү. Үүнийг гишүүд дэмжвэл.

Тэгэхдээ зарчмын санал гаргах ёстой байх. Тэгээд гаргаад хураалгаад явах байх шүү.

Ингээд Д.Батлут гишүүн асуулт асууж, саналаа хэлье. Зэрэгцээд хурлууд давхцаад байгаа шүү. Д.Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

**Д.Үүрийнтуяа:** Би асуулт асуухгүй. Үг хэлэх гэсэн юм. Тогтоолтойгоо холбоотой. Ажлын хэсгийн гишүүний хувьд.

Ажлын хэсэг дээр гишүүд энэ асуудлыг бас олон талаас нь янз янзын хувилбараар нэлээдгүй гарц гаргалгаа хайж удаан ярилцсан. Салбарын яамтай ч ярьсан. Хариуцан гүйцэтгэж байгаа Газрын тосны газрыг газрын тосны үйлдвэрийг хариуцаж байгаа төслийн нэгжийнхнийг, Сангийн яамны холбогдох мэргэжилтнүүд, яамны холбогдох мэргэжилтнүүд, Усны газар гээд ингээд л бүх л талаас нь бид нэлээн ярилцсан.

Тэгээд яг одоо дэгээрээ үндсэндээ энэ хэлэлцээр нөгөө Их Хурлын дэргэдэх харьяаллын гурван Байнгын хороогоороо ороод дэмжигдээд орчихсон. Чуулганд орчихсон. Яг энэ хэлэлцээр дээр Сангийн яам Б.Жавхлан сайд маань гарын үсэг зурчихсан гэж ойлгоод байгаа. Хэлэлцээр зурчихсан. Яг Ц.Туваан сайдын өчигдөр бидний хийсэн уулзалт дээр одоо хэлэлцээрийн ямар нэгэн зүйл, заалтыг өөрчлөх боломжгүй гэдэг ийм зүйлийг хэлж байгаа.

Тэгэхээр яг энэ нөхцөл байдалд бид нарт тогтоол гаргахаас өөр хувилбар байхгүй болчихоод байгаа юм. Өөр хувилбар байхгүй болчихоод байгаа юм.

Сая сайд хэлэхдээ нэмэлт хэлэлцээр юм гэж хэлж байгаа. Тийм ээ. 2019 оны хэлэлцээрээр 236.0 сая доллар авсан энэ хэлэлцээрийг тодотгох нэмэлт хийх замаар 464-өөр нэмэгдүүлж байгаа. Өөрөөр хэлбэл энэ 236-г нэмээд 700 болж орж ирж байгаа юм л гэдэг ийм зүйлийг ярьж байгаа. Гэхдээ нэмэлт өмнөх нь хүчингүй болохгүй л дээ.

Тэгэхээр энэ бол шинэ хэлэлцээр болж тараад байгаа байхгүй юу. Өмнөх 2019 оны хэлэлцээрийг хүчингүй болгоно гэж өчигдөр бид нарт, ажлын хэсгийнхэнд тийм тайлбарыг өгсөн.

Тэгэхээр зүгээр энэ дээр гол анхаарах ёстой асуудал нь юу гэхээр одоо нэгэнт зурагдчихсан, өөрчлөх боломжгүй хэлэлцээр дээр бид ямар нэгэн санал гаргаад үр дүнгүй болчихоод байгаа юм л даа.

Ажлын хэсгийнхэн тал талаас нь ярьж асуудал болгож авч үзсэн зүйл бол зөвхөн үнийн өсөлтийн асуудал ярьж байж яагаад энэ тодорхой заалтууд дээр ийм хатуу нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрчхөв л гэдэг зүйлийг яриад байгаа юм.

Тэр нь нэгдүгээрт та бол одоо бид өөрсдөөс хамаарах зүйлээ хийчихсэн байя л гэж байгаа юм. Гэтэл ямар нэгэн байдлаар нөгөө тал гэрээний үүргээ хэрэгжүүлж чадахгүйгээр гэдэг юм уу, ЭКСИМ банк бид нарт санхүүжилтийнхээ асуудлыг л өгч байгаа шүү дээ.

Гэтэл нөгөө Энэтхэгийн талаас магадгүй 25-аас 50 хувь нь Монголын компаниуд, эсвэл өөр орны компаниуд гүйцэтгэх боломж нь нээлттэй байгаа байхгүй юу. Тэд нартай холбоотой гэрээний үүргийн хэрэгжилт зөрчигдөх юм бол нөхөн төлбөрийн заалт нь нэлээн хатуу.

Эргээд шүүхийн маргаан дээр бид нарт магадлал их багатай. Ийм л нөхцөл байдал дээр л ажлын хэсэг бас санаа зовж. Энэ асуудлуудыг ер нь анхаарч Засгийн газар анхааралтай байлгаж ажиллаач ээ гэдэг үүднээс энэ тогтоолын төслийг оруулъя, Байнгын хороогоороо хэлэлцүүлье гэдэг саналтай л орж ирж байгаа юм.

Ер нь энэ хэлэлцээрийг ямар ч байсан яваад үргэлжлээд энэ ажил нь дуусах ёстой гэдэг дээр гишүүд зарчмын хувьд нэгдэж байгаа. Тэгэхдээ энэ асуудлыг Засгийн газарт тодорхой үүрэг өгөх нь зүйтэй гэдгээр л тогтоолын төсөл орж ирж байгаа юм гэдгийг гишүүдэд бас хэлэх гэсэн юм.

**С.Ганбаатар:** Гишүүд маань асуулт асуулаа. Би хоёр, гурван тодруулах асуулт байгаа.

Ер нь энэ газрын тосны үйлдвэр нь заавал босох ёстой, хэрэгжих ёстой. Хэн ч эсэргүүцээгүй. Гэхдээ өнөөдрийн байдлаар зүгээр гарцаагүй баталгаатай босохгүй болчихсон байгаа үед үүнийг зүтгүүлээд явна гэдэг бол ай даа мөн том эр зориг шүү.

Тэр н.Мөнхбат гээд нэг банкны захирал залуу ямар ч ТЭЗҮ-гүй зээл өгсөн байна гээд л 5 жил шоронд явчихлаа шүү дээ. Тэгээд одоо энэ 126-г багтаах газар байдаг юм уу, үгүй юу. Одоо мэдэхгүй. Аюултай л юм хийж байна даа бид.

Тэгэхээр нягталж баталгаажуулъя л гэж би гуйгаад байгаа. Ер нь Монголын ард түмэн хэнд ч өргүй. “Орано” байна уу, Э.Макронд бид ямар ч өргүй, “Рио Тинто”-д өргүй.

Энэ Энэтхэгийн хэдэн технологийг. Би зээл гаргасанд баярлаж байгаа. Тэгэхдээ энэ тоног төхөөрөмжийн шахаанд бид ямар ч өргүй. Монголын улс төрчид ганцхан Монголын ард түмэнд л өртэй. Ажилтай орлоготой, үйлдвэртэй байлгах ёстой.

Тэгээд би тодруулах хэдэн зүйл байгаа юм. Энэ ТЭЗҮ нууц байгаа. Нууцалсан эрх зүйн байдал ерөөсөө тайлбарлахгүй байгаа. Тэр дотор эдийн засгийн үр ашгийн тооцоо. Мэдээж ТЭЗҮ нууц юм чинь тэр тодорхойгүй. Техник, технологийн сонголт тодорхойгүй. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ тодорхойгүй.

Тэгэхээр **FEED**<sup>3</sup>[Front-End Engineering Design] гэж ярьдаг юм даа. ТЭЗҮ-д үндэслэсэн технологийн зураглал. Зураг төсөл ч бас хийгдсэн нь тодорхойгүй. Ийм үед хатан зоригтойгоор бид шийдвэр гаргах гэж байгаа.

Миний тодруулж асуух асуулт. ТЭЗҮ хэзээ тодорхой болох вэ? Хүний нэр яриад байх вэ. Хөөрхий. Дөнгөж сая 3 цагийн өмнө надад орж ирсэн бичиг дээр таны асуусан энэ техник, эдийн засгийн үндэслэл эх хувь нь манай компанийн төрийн хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэгч “Эрдэнэс Монгол” компанид хадгалагдаж байгаа тул компанийн нууцын журмаар хүргүүлэхээр ажиллаж байна.

Гишүүд минь одоо тэгээд гуйна даа. Хоолонд оруулдаг л байх даа. Хэдүүлээ. Өөрөөр хэлбэл та нарт өгөх боломжгүй. Тэр эдийн засгийн үр ашгийн тооцоо энэ дотор байдаг юм аа, чи юмаа мэддэггүй юм уу гэж хэлж байна.

Үүнийг би хэзээ авч болох вэ? Энэ дээр надад хариулах хүн байгаа болов уу? Байгаа бол надад их сайн байна.

Хоёрдугаарт, Газрын тос ТЭЗҮ-д үндэслэсэн техникийн зураг, төсөл гэж FEED гэж яриад байгаа юм шүү. Тэр хэзээ авч болох вэ?

Гуравдугаар асуулт. Ерөнхий гүйцэтгэгч нь яг хэн юм? Ерөнхий гүйцэтгэгч нь газрын тосны үйлдвэрийн газар л гэж хэлэх байх л даа. Тэгвэл ерөнхий гүйцэтгэгч нь ерөнхий захиалагч нь байж болдог юм уу?

Би өөрөө өөрийнхөө хашааг өөрөө будчихаад дараа нь муухай будсан байна гээд өөрийгөө алгадаж унагаалттай нь биш дээ. Энэ дээр та нар хариулт өгөөч. Хэн ерөнхий гүйцэтгэгч юм?

---

<sup>3</sup> Төслийн зардлыг хянах, тендерийн үнийн санал ирүүлэхээс өмнө төслийг сайтар төлөвлөхөд ашигладаг инженерийн дизайны арга. [Үүнийг мөн төслийн өмнөх төлөвлөлт \(PPP\), урд талын ачаалал \(FEL\)](#), техник эдийн засгийн үндэслэлийн шинжилгээ эсвэл төслийн эрт төлөвлөлт гэж нэрлэж болно.

---

Түүхий тос, усны хангамжийн баталгаа тооцоо тодорхой бус байгаа. Энэ дээр байхгүй гэж хэлсэн байгаа шүү. Бүр бичиг нь дөнгөж сая өнөөдөр 2 цагийн өмнө ирсэн шүү. Тэрийг хэзээ авч болох вэ? Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэхэд ашиглах техникийн лиценз буюу эрхийн тухай тохиролцоо. Энэтхэгүүдтэй би гэрээнд орчихсон. Одоо би та нарт өгөх боломжгүй байна гэж байна. Би хэзээ авч болох вэ? Тэгээд хариулчихсан байна.

Энэтхэгийн ЭКСИМ банкттай байгуулсан зээлийн гэрээг би үзмээр байна гэсэн. LOAN AGREEMENT. Тэгсэн чинь энэ бол Сангийн яаман дээр байгаа. Тэндээсээ шууд үзчихээч ээ гэж байна. Тэр үнэн үү? Одоо би чинь итгэхээ больчихсон шүү дээ. Яг үнэн үү? Байгаа юу? Хэзээ өгч болох вэ?

Газрын тос боловсруулах үйлдвэрт түүхий тос нийлүүлэх тухай ерөнхий гүйцэтгэгчтэй байгуулсан үндсэн гэрээ. Түрүүн Д.Пүрэвдаваа гишүүн асуусан. Шүүх мүүх дээр бөөн өртэй байгаа шүү дээ. Энэ үндсэн гэрээг хэзээ авч болох вэ? Ашигт малтмалын газрын тосны газар дээр байгаа. Наад Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаасаа аваач ээ. Яагаад надаас асуугаад байгаа юм бэ гэж ундууцсан байдлаар яг энэ үгийн үсгийн хэлбэрийг нь хараад би хэлдэг болчихоод байгаа шүү дээ. Асууж байна. Энэ байгаа юу? Хэзээ авч болох вэ?

Яг энэ гэрээн дээр заасан нэг асуулт. Олон юм байна даа. Би энэ 15 асуултаас чинь. Миний цаг бас байгаа байх.

Түүхий тос, усны хангамжийн баталгаа тооцоо юу ч байхгүй. Энэ дээр би өнөөдөр судалж судалж үзсэн. 1986 онд манай Улаанбаатар хотын геологийн газраас тэр Бор хөөврийн говийн усны судалгааг би үзлээ. Юу ч байхгүй гэж гарсан байна лээ шүү. Энд байна. Бор хөөврийн говьд 1986 онд Улаанбаатар, Геологийн удирдах газар усны хайгуул хийсэн. Юу ч байхгүй ээ гэдэг нь. Геологичид нь 3 геологич байна. Нэр усыг нь яриад яах вэ. Дараа нь н.Жадамбаа гэдэг геологич бас нэмэлт тайлан бичсэн. 2012, 2013 онд юм уу. Байхгүй ээ гэж байгаа юм. Тэгээд одоо бол “та таа, тунгааддаг” цаг болчихсон шүү дээ. Ингээд л өөр газраас хайдаг болсон.

Тэгэхээр энэ дээр энэ мэдээллүүдийг би хэзээ авах боломжтой вэ? Би ямар нэгэн улс төржүүлээгүй шүү. Би цэвэр техникийн асуулт асууж байгаа. Шийдвэр гаргахаасаа өмнө би эдгээрийг авах ёстой шүү. Би асуултдаа хариулт авъя.

Ц.Туваан сайд хариулъя. Дараа нь Б.Жавхлан сайд хариулна.

**Ц.Туваан:** Аж үйлдвэржилтийн байнгын хорооны дарга болон эрхэм гишүүддээ энэ оройн мэндийг хүргэе.

Тэгээд энэ чухал асуудлаар цаг наргүй, орой үдэшгүй сууж ажиллаж байгааг ойлгож байна. Тэгээд баярлаж байна. Би бас асуудал хэлж, ажлын хэсгийн нэр өгөөгүй байсан учраас хоцроод ирлээ. Хүлцэл өчье.

Энэ ТЭЗҮ-тэй холбоотой асуудал. Мэдээж ТЭЗҮ байгаа. Гарсан. Энэ ТЭЗҮ-тэй холбоотой асуудлыг 2019 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 247 дугаар Засгийг газрын дугаартай тогтоолоор төрийн нууцад авсан.

Төрийн нууцад авсан. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу энэ асуудал шийдэгдсэн. 20 жилийн хугацаатай нууцад авсан.

Л.Мөнхбаясгалан дарга надад хэлээд. Энэ асуудлыг гишүүд ил болгож авмаар байна гээд. Тэгээд түрүүчийн ажлын хэсгийн хурал дээр С.Ганбаатар дарга үзэхийг бол хэн ч үзчихнэ. Ямар ч байсан ил болгож авмаар байна гээд. Энэ асуудлыг Засгийн газар дээр би өнөөдөр Засгийн газарт асуудал болгож гэж ойлгуулсан юм шиг байна лээ. Би Засгийн газар дээрээ очоод нууцыг хариуцсан дарга, ажилтнууд байдаг. Тэгээд энэ нууцыг хариуцсан дарга, ажилтнууд болон өөрийн яамны нууц хариуцсан мэргэжилтэнтэй уулзаж асуусан.

Төрийн болон албаны нууцыг дараах үндэслэлээр ил болгоно гээд 19 дүгээр зүйлийн 1 дээр нь 4 үндэслэл заасан байгаа.

- ▷ Нууцлах хугацаа дуусгавар болсон буюу 20 жил дууссан бол.
- ▷ Нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас төрийн болон албаны нууцад хамааруулсан тодорхой мэдээллийг цаашид нууцлах шаардлагагүй болсон.
- ▷ Тухайн мэдээллийг төрийн болон албаны нууцад хамаарахгүй болгосон хууль батлагдаж хүчин төгөлдөр болсон.
- ▷ Мэдээллийг үндэслэлгүйгээр нууцалсан нь тогтоогдсон гэсэн ийм 4 үндэслэлээр.

Тэгээд энэ 4 үндэслэлээр нь аль нэгийг нь сонгож аваад ил болгоё гээд цаашаа явбал яах вэ гээд үзэхээр энэ харилцааг 19.2-т зохицуулсан байгаа юм.

Үүнийг 19.6-д заасан журмын дагуу ил болгоно гээд. Ямар журам бэ гээд явахаар төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийн энэ зүйлийн 19.1.2-т заасан үндэслэлээр буюу нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас төрийн болон албаны нууцаас гарах энэ мэдээллийг цаашид нууцлах шаардлагагүй болсон гэж үзвэл нууцлах хугацаа дуусахаас өмнө ил болгох эсэхийг тагнуулын байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэх юм билээ.

Тэгэхээр тагнуулын байгууллагатай бид ярьж байж шийднэ.

Тэгээд энэ дотор нь дахиад цааш нь үзэхээр төрийн болон албаны нууцыг нууцаас ил болгох асуудал дээр тагнуулын байгууллагатай яаж шийдэх вэ гэхээр тагнуулын байгууллагын дүгнэлтийг гаргуулна.

Тэгээд энэ дүгнэлтийнхээ дагуу ажлын хэсэг байгуулж. Одоо бодвол яам, тагнуулын байгууллага хоёр хамтарч ажлын хэсэг байгуулж ажиллаад тэгээд эндээс шийдвэр гаргаад Засгийн газраар эцсийн шийдвэр гарснаар хүчин төгөлдөр болох юм байна лээ.

Тэгэхээр энэ нэлээн тийм процесстой. Яг өчигдөр яриад, өнөөдөр би гаргах эрх байхгүй. Тэгээд ийм зүйл байлаа шүү. Тэгээд манайх үүнийг бас ойлгоно биз.

Улсын Их Хурлын гишүүд орж танилцах эрх нь байгаа гэдгийг бид мэдэж байгаа.

Энэ ажлын хэсэг дээр манайхаас яг салбартай холбоотой саяын Байнгын хороон даргын асуусан асуултад хариулах зүйл байвал манай Газрын тосны газрын дарга ирсэн байгаа. Хариулна биз.

Би энэ дээр нэг бас Улсын Их Хурлын гишүүнийхээ хувиар, энэ салбарын сайдын хувиар 5-хан зүйл хэлчихье.

Энэ хоёр асуудлыг ялгаж ойлгоосой гэж.

**С.Ганбаатар:** Ц.Туваан сайдад нэмэлт минут өгье.

**Ц.Туваан:** Ялгаж ойлгоосой гэж. Ямар юм ялгаж ойлгох гэж байна вэ гэхээр Б.Жавхлан сайдын оруулж ирсэн, Сангийн сайдын оруулж ирж байгаа Энэтхэгийн ЭКСИМ банктай хийж байгаа зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын хуулиар Улсын Их Хурал соёрхон баталдаг.

Энэ процесс нэлээн удаан буюу жил 6 сар. Манайхан хүсэлт юм даа. Боловсон хэлбэл хүсэлт. Жоохон бүдүүлгээр хэлбэл Энэтхэгийн талаас нэмж өгөөч ээ гэж гуйж хүсэлтээ тавиад Ерөнхий сайдын маш олон удаагийн захидлууд яваад дипломат шуудан юм хумаар харилцаж байгаад энэ хүсэлтээ 2024 оны 12 сард ирүүлсэн.

Тэгээд л нөгөө “гуйх хүн бөхийж, өгөх хүн гэдийдэг” гэдэг шиг л юм болсон.



Тэгээд тэгж байгаад 3 хатуу заалт оруулж ирсэн. Түүн дээр нь Сангийн яам ажлын албатайгаа, аппараттайгаа хэлцэл хийж байгаад аятайхан болгоод оруулсан. Ингээд үүнийгээ тохироод бид бүхэн Монгол Улсын хууль, процессын дагуу Байнгын хороодоор ороод зөвшөөрлөө аваад Сангийн сайд зураад явуулаад нөгөө тал зураад, одоо Их Хурал руу л орж байгаа асуудал. Энэ нэгдүгээр асуудал шүү.

Би энэ асуудал дээр. Минут нэмж өгч болох уу? Дарга аа.

**С.Ганбаатар:** Ц.Туваан сайдад нэмэлт минут өгье.

**Ц.Туваан:** Би энэ асуудал дээр хоёр тусдаа асуудал гэдэг нь энэ Сангийн сайд оруулж ирж байгаа. Энэ зээл, энэ төсөл цаашаа явах уу, үгүй юу гэдгийг шийдэх ийм амин чухал шийдвэр. Нэг.

Хоёр дахь асуудал нь мэдээж үүнийг, хэрвээ надад боломж байдаг бол Байнгын хорооны дарга болон гишүүдээс асуучихмаар байгаа юм. Үнэхээр энэ асуудлыг хэдүүлээ цуг цааш нь явуулаад дуусгахын төлөө ажиллах хүсэлтэй байна уу ч гэдэг юм уу. Одоо бас зарим нь битгий буруугаар ойлгоорой. Энэ яагаад байгаа юм. Байнгын хороод гишүүдийн өөдөөс асуугаад байгаа юм уу гэж буруугаар битгий ойлгоорой.

Хоёр дахь хэсэг дээр нь би Засгийг газрын ажлын хэсгийн энэ ажлыг эрчимжүүлэх ажлын хэсгийн дарга. С.Ганбаатар дарга бол Байнгын хорооны дарга бөгөөд Л.Мөнхбаясгалан гишүүн үүнийг бас эрчимжүүлэх ажлын хэсэг гэж ойлгож байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурал, Засгийн газар хоёулаа хавчаад хамтраад энэ асуудлыг бүр цааш нь сайжруулаад ингээд цаг.../минут дуусав/

**С.Ганбаатар:** Б.Жавхлан сайд хариулт өгье.

**Б.Жавхлан:** С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Зээлийн гэрээ байлгүй яах вэ. Зээлийн гэрээ бол ямар ч нууцлал байхгүй шүү. Биднээс асуусан бол бариад л гүйгээд ирнэ.

Ажлын хэсэг биднээс зээлийн гэрээгээ явуул гэсэн. Явуулсан, хүргүүлсэн байгаа. Тийм. Зээлийн гэрээн дээр нууцлалын асуудал ерөөсөө огт байхгүй шүү.

**С.Ганбаатар:** Сүүлдээ байгаа, өгье гэхээр би баярладаг болчихоод байгаа юм. Нээрээ даруйхан авъя.



Яагаад гэвэл Монголын ард түмэнд энэ хэрэгтэй. Ер нь ТЭЗҮ-гүйгээр шууд шийдвэр гаргаад явчихдаг нэг хуультай л болчихвол тэгээд болчих юм биш үү? Монгол жаргачих юм биш үү?

8 номер нэмэлт тайлбар өгье.

**Ч.Хишигдалай:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай.

Өнөөдөр бид Төрийн албаны нууцын тухай хуулийн дагуу бүх процессыг гүйцэтгээд техник, эдийн засгийн үндэслэлийг Улсын Их Хурлын Тамгын газрын нууцын эрхлэгчид хүлээлгэж өгсөн.

Өнөөдөр 17.00 цагт. Одоо Улсын Их Хурлын Тамгын газар ТЭЗҮ бүтнээрээ байгаа. Үүнийг мэдээлэл болгож Та бүхэнд хүргэж байгаа юм.

Бусад тэр газрын тос нийлүүлэхтэй холбоотой гэрээг би сая Аж үйлдвэржилтийн байнгын хорооны ажлын албаны Д.Гэрэлт-Одод шууд дижиталаар нь өгчихлөө.

Таны бусад асуусан гэрээнүүдийг Газрын тос боловсруулах үйлдвэрийнхэн флаш, дижитал хэлбэрээр өгсөн гэсэн мэдээлэл байна.

**С.Ганбаатар:** Маш их баярлалаа. Энэ мэдээллүүдийн сургийг нь сонсоно гэдэг чинь бас л үнэхээр баяр шүү.

Тэгээд юун дээр байгаа юм байна? Тэгээд наадах чинь маргааш батлах гээд байгаа юм байдаг. Үзэж хармаар байдаг. Ямар ч байсан сураг сонсоно гэдэг чинь том давуу тал.

Тэгэхээр би хэд хэдэн асуулт. Ажлын хэсгийн ахлагчаас асуух асуултууд байгаа. Тэрийгээ би санал дээрээ хэлчихье. Бас энэ чинь Байнгын хорооны дарга хоёр дахь удаагаа асуулт хамаагүй асууж болж байна уу, үгүй юу.

Ингээд гишүүд асуулт асууж, саналаа хэлж дууслаа. /алх цохив/

Одоо тогтоолын төсөлтэй холбогдуулж санал гаргах гишүүд нэрсээ өгнө үү? Тийм. Б.Тулга сайдынх байгаа. Зарчмын зөрүүтэй саналууд өөр байгаа юу?

Ингээд Д.Пүрэвдаваа гишүүнээр тасаллаа. Надад санал байгаа. Ингээд тасаллаа.

Д.Пүрэвдаваа гишүүний микрофоныг нээж өгье.

**Д.Пүрэвдаваа:** Дэгийн тухай хуулийнхаа дагуу Байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй саналаа гаргах эрх нь байгаа.

Түрүүний С.Замира гишүүний саналтай санал нэг байна.

Энэ бүх зүйл тодорхойгүй байгаа. Ялангуяа би 5 минутад ногдож байгаа хугацаанд үгээ хэлж байгаад саналаа тавья гэж бодож байна.

Нэгдүгээрт, энэ утааны асуудал гэхэд бас л нууцад авч байгаад л үйлдвэрээ авсан. Түгжрэлийн асуудал гээд л тэгнэ. Нууцад авч байгаад л автобусаа авсан.

Ямар компанийн ямар юманд нийлүүл гэдгийг нь мэддэггүй. Дараа нь бүр хүлээгээд авчихсаныхаа дараа л ард түмэн мэдээд үүнийг буцаах ёстой байсан гээд асуудал үүсдэг.

Тэгэхээр энэ үйлдвэр одоо энгийнээр машинаар зүйрлэвээс Энэтхэгийн үйлдвэрийн машин юм уу, Японы Тоёотагийн загварын үйлдвэр юм уу. Тийм үү. Үүнийгээ бид мэдэх боломжгүйгээр төсөвт өртгийг нэмж байгаа.

Энэ юу гэж харагдаж байна вэ гэхээр зэрэг 3 намын бүлэг нийлсэн ашиггүй, санхүүгийн хувьд ч өгөөжгүй, эдийн засгийн хувьд ч өгөөжгүй. Өнөөдөр нийт хэрэглээнийхээ 2.8 сая тонн шатахуун 2024 онд хэрэглэсэн байгаа юм. Энэ хэрэглээнийхээ 10 хувьд хүрэх юм уу, үгүй юу гэдэг нь тодорхойгүй ийм үйлдвэрийн төслийг санхүүжүүлэх ажлыг бид яг дэмжих гээд байна. Уг нь зээл авах нь буруу биш. Зээлийг өгөөжтэй, санхүүгийн бөгөөд эдийн засгийн хувьд өгөөжтэй энэ төсөл рүүгээ оруулах нь зүйтэй.

Тэгэхээр гишүүний хувиар энэ тодорхойгүй, шийдвэр гаргах боломжгүй харанхуй шийдвэр гаргалтаасаа бид болих хэрэгтэй.

Тэгэхээр энэ зарчмын зөрүүтэй санал тавьж энэ асуудлыг тодорхой хугацаагаар хойшилъя. Тэгээд тэр нууцад байгаа асуудлуудыг ил гаргаж байгаад тэгээд дараагийн тэр санхүүжилтийн асуудлаа ярих нь зүйтэй байх гэж зарчмын зөрүүтэй санал гаргаж байна. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Сая бол нөгөө орж ирж байгаа асуудалтай хөндөгдөөгүй асуудал байна. Ажил хэрэгч саналууд байна. Үүнийг тэгээд бас холбогдох манайхантай зөвлөлдөөрэй.

Ингээд Б.Тулга сайдын саналыг хураалгана. Дараа нь миний бичгээр өгсөн санал байгаа. Тэрийгээ би бас хураалгана.

Ингээд төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёололыг би Та бүхэнд уншиж танилцуулъя.

Саналын томъёолол нь төслийн 2 дахь дэд заалтын “2028 оны 1 дүгээр улиралд багтааж” гэснийг “ЕРС-4 гэрээнд туссан томъёололтой уялдуулсан гэрээ зурагдсанаас хойш 38 сарын дотор багтааж” гэж өөрчлөх гэсэн ийм санал гаргалаа.

Ингээд зарчмын зөрүүтэй санал гаргасан Б.Тулга гишүүний саналыг дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал. Энэ тогтоолын төсөлтэй холбогдуулж би зүгээр найруулгын утга агуулгын чанартай зүйлүүд байгаа учраас заавал санал хураалгах байх.

Олон улсад нефть боловсруулах үйлдвэрийн төсөлд тавигддаг шаардлагын дагуу эдийн засгийн үр ашиг, техник, технологи, байгаль орчны хувьд боломжтой гэдгийг техник, эдийн засгийн үндэслэлээр баталгаажуулсан байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх гэдэг ийм томъёоллын саналыг би оруулж байна. Дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү.

Санал хураалтыг цуцалъя.

Олон улсад нефть боловсруулах үйлдвэрийн төсөлд тавигддаг шаардлагын дагуу гэж байгаа юм шүү. Энэ бол Дэлхийн банк дээр өөр дээр нь стандарт байдаг. Тэгээд заавал Дэлхийн банк гэхгүйгээр “олон улсад нефть боловсруулах үйлдвэрийн төсөлд тавигддаг шаардлагын дагуу эдийн засгийн үр ашиг, техник технологи, байгаль орчны хувьд боломжтой гэдгийг техник, эдийн засгийн үндэслэлээр баталгаажуулсан байх арга хэмжээг. Тогтоол дээр би санал оруулж байна шүү.

Тэгвэл ажлын хэсгийн ахлагч Л.Мөнхбаясгалан гишүүн саналаа хэлнэ.

**Л.Мөнхбаясгалан:** Хоёр логик харагдаад байна.

Энэ тогтоолын төсөл соёрхон батлахыг дэмжсэн тогтоолын төсөл биш. Яагаад гэвэл бид одоо олонхоороо хэрвээ түрээд Улсын Их Хурлаар соёрхон батлах юм бол бид ямар ямар заалтыг яаж яаж хөндөж Засгийн газарт хяналт тавьж ажиллах юм. Яаж тэр нууцад байгаа ТЭЗҮ, аудитын дүгнэлтийг яаж гаргах юм. ЕРС-4 дээр яаж хяналт тавих юм. Яаж дотоодын өндөр мэргэжилтэй залуучууд энэ газрын тос боловсруулах үйлдвэр лүү яаж шалгалт хийх юм.

2020 оноос хойшоо аудит хийгээгүй байгаа. Аудитыг яаж хийх юм. Тэгвэл та нар өөрсдөө тайлбарлаад өг дөө.

Энэ ийм даалгавар өгч байгаа тогтоолын төсөл болохоос биш соёрхон батлахыг дэмжээд өгөөч гэсэн тогтоолын төсөл биш.

Газрын тос боловсруулах үйлдвэрийг 2028 оны 1 дүгээр улиралд багтааж ашиглалтад оруул гэдгийг хэн, хаана хяналт тавих юм. Тэгвэл. Хэрвээ энэ тогтоолын төсөл байхгүй юм бол, энэ тогтоолын төсөл хэрэггүй юм бол.

**С.Ганбаатар:** Одоо бол хэлэлцэх асуудал зарчмын зөрүүтэй санал. Д.Пүрэвдаваа гишүүний асуудлыг ярьж байгаа шүү дээ.

Д.Пүрэвдаваа гишүүний ярьж байгаа юмыг л хураах уу, хураахгүй юу гэдэг асуудал ярьж байгаа шүү дээ. Энэ дээр.

Ажлын хэсгийн гишүүн, Д.Үүрийнтуяа гишүүний микрофоныг нээж өгье.

**Д.Үүрийнтуяа:** Энэ манай Байнгын хороодын гишүүд буруу ойлголттой байгаад байх шиг байна. Тогтоолын төслийн талаар.

Энэ тогтоолын төсөл тэртээ тэргүй одоо энэ 464 ярьсан яриагүй өмнө нь 1.2 тэрбум долларын асуудал чинь явж байгаа шүү дээ. Ажил нь эхэлчихсэн явж байгаа шүү дээ. Тэрийгээ л гүйцэтгэлийг нь шаардах юмаа л яриад байгаа шүү дээ. Энэ ажлыг ерөөсөө. Нэмээд явсан ч гэсэн энэ ажил чинь тэр зарцуулалтад нь, гүйцэтгэлд нь бид хяналт тавих чиг үүрэгтэй биз дээ.

Тэгэхээр энэ тогтоол гарснаараа сүүлийн хэлэлцээрийг дэмжиж байгаа юм шиг, эсвэл энэ тогтоол гарснаараа хууль зөрчиж байгаа юм шиг ойлголт байгаад байж болохгүй л дээ.

Тэгэхээр энэ чинь ялгаатай ойлголт байхгүй юу. Тэгээд энэ ажлын хэсэг хэрэггүй энэ тэр гээд бүр өөр ойлголт ороод явчихлаа.

Энэ ажлын хэсэг чинь өөрөө газрын тосны үйлдвэрийн хийсэн хэлэлцээр, одоо энэ хийгдэж байгаа ажлыг чинь ерөөсөө анхнаас нь эхлээд дуустал нь хянаж шалгах ажлын хэсэг шүү дээ. Түүнээс биш энэ хэлэлцээрт зориулсан ажлын хэсэг ерөөсөө биш байхгүй юу.

Яг энэ ажлын хэсгийг ажиллаж байх явцад хэлэлцээрийн асуудал яригдаж байгаа учраас бид энэ дээр тодорхой үзсэн хүрээндээ, судалсан материалынхаа хүрээнд тодорхой үүрэг даалгаврыг Засгийн газарт өгөх нь зүйтэй байна гэдэг байдлаар л оруулж байгаа юм.

**С.Ганбаатар:** Ажлын хэсгийн гишүүд хариулж байгаа юм шүү. Г.Очирбат гишүүний микрофоныг нээж өгье. Ажлын хэсгийн гишүүн, Г.Очирбат гишүүн.

**Г.Очирбат:** Манай Аж үйлдвэржилтийн байнгын хороо, мэргэжлийн Байнгын хорооноос мэргэжлийн ажлын хэсэг гарсан.

Ажлын хэсгийнхэн үнэхээр хүнд нөхцөлд ажилласан. Байнгын хорооны эрхэм гишүүд минь үүнийг бас хүндлэх хэрэгтэй шүү. Бид нарт мэдээллүүд их нууц байсан. Бүх мэдээллээ төрийн нууцад авчихсан гээд өгөхгүй байсан. Тэгээд олон талаас нь мэдээллийг шахаж шаардаж байж аваад өнөөдөр Засгийн газарт чиглэл өгөх ийм Байнгын хорооны тогтоолыг боловсруулсан.

Тэгээд энэ бол маргаашийн болох санал хураалттай хамаагүй. Ямар ч байсан ажлын хэсэг Байнгын хорооноос зохион байгуулагдсан ажлын хэсэг ажлаа хийгээд яг энэ газрын тосны үйлдвэртэй холбоотой асуудлууд дээр ийм 7 чиглэлээр Засгийн газар чиглэл өгөх ёстой юм гэсэн тогтоолыг санал болгож байгаа. Тэгээд Та бүхэн маань дэмжиж өгөөрэй гэж хүсэх гэсэн юм.

Яагаад гэхээр энэ дээр нэлээн чухал чухал асуудлууд орсон байгаа. Тэгээд Та бүхэн уншиж байгаа байх. Тэгээд дэмжиж өгөхийг хүсье.

**С.Ганбаатар:** Тэгье. Тэгвэл санал дээр байна шүү дээ. Томьёолол дээр би нэг тийм редакцын маягтай хэдэн саналуудаа бас заавал протоколд тусгаж оруулмаар байна.

Жишээ нь, та нар харж байгаа бол тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт хангалтгүй тохиолдолд холбогдох албан тушаалтан, тухайн жилийн төлөвлөгөөг жил бүр батлах гээд. Энэ үг бол нэгэнт ТЭЗҮ, FEED гэдэг юман дотор нь бидэнд тодорхой болчих л юм бол энэ дотор чинь эхнээс нь аваад дуусах хүртэл үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнг эзэн биетэй нь, мөнгө төсөвтэй нь бүгдийг нь заачихсан байдаг.

Тэрийг Засгийн газар жил болгон батлах заавал албагүй.

Энэ мэтчилэн ийм найруулгын хэдэн зүйлүүд. Би өөрөө дэмжиж байна. Найруулгын хэдэн зүйлүүд байгаа учраас. Жишээ нь, үйлдвэр ашиглалтад орох үед хэрэгцээтэй дотоодын түүхий тосоор бүрэн хангах бодлогыг хэрэгжүүлэх гэж байгаа. Дотоодоосоо бүрэн хангана шүү гээд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарчихсан байгаа. Үүнийг заавал бид Засгийн газарт үүрэг өгөх хэрэг байна уу гэсэн ийм найруулгын чанартай асуудлуудыг би уншаад тэгээд баталгаажуулахыг хүсэж байна.

Нэгдүгээрт, “олон улсад нефть боловсруулах үйлдвэрийн төсөлд тавигддаг шаардлагын дагуу” гэдэг үг найруулж оруулах хэрэгтэй байгаа юм.

Тэгэхгүй “Энэтхэгийн шаардлагын дагуу” гэх юм бол тэр чинь халуун орон. Олон улсын шаардлагын дагуу эдийн засгийн үр ашиг, техник технологи,

байгаль орчны хувьд боломжтой гэдгийг техник, эдийн засгийн үндэслэлээр баталгаажуулсан байх.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн техникийн зураг төсөл, FEED гэж бүр заавал ч үгүй би үүнийг нь тодруулж хэлж байгаа юм. Үйлдвэрийн технологийн тоног төхөөрөмжийн жагсаалт, үйлдвэрийг барьж байгуулах зардлын төсөв, барилга угсралтын ажлын график төлөвлөгөөг олон улсын стандартын дагуу үйлдвэрийн барилга угсралтын ажил эхлэхээс өмнө бүрэн боловсруулах баталгаажуулсан байх.

Энэ чинь зүгээр мэдээжийн юмнуудыг ярьж байгаа юм шүү дээ. Ажлуудаа баталгаажуулахын тулд. Энэхүү техникийн зураг төсөл, FEED-ийн үйлдвэрийн технологийн тоног төхөөрөмж нийлүүлэх, үйлдвэрийг барьж байгуулах төсөв, барилга угсралтын ажлын графикийн дагуу барилгын ерөнхий гүйцэтгэгчтэй үйлдвэр барьдаг угсралтын ажлыг гүйцэтгэж, түлхүүр гардуулах нөхцөлөөр байгуулсан EPCC<sup>4</sup> [Engineering, Procurement, Construction and Commissioning] гээд байнга яриад байгаа юмыг нь л би гэрээ хийж баталгаажуулсан байх арга хэмжээг авах. Энэ бүр тодруулж л байгаа хэрэг. Энэ дотор ярьсан зүйлүүдийг.

Дөрөвдүгээрт нь, үйлдвэрийн түүхий тос цэвэр усны нөөцөөр хэрхэн баталгаатай хангахтай холбогдсон дүгнэлт. Хэрэв дээрх хоёр нөхцөлөөр хангах боломжгүй бол хэрхэн шийдэх тухайгаа Улсын Их Хуралд танилцуулах арга хэмжээг авсан байх. Хэрэгжүүлэх.

Тавдугаарт, энэ үйлдвэр нь өөрийн ашгаас нийт хөрөнгө оруулалтаа нөхөн төлөх баталгаат тооцоог Улсын Их Хуралд ирүүлсэн байх арга хэмжээг авах гэсэн ийм 5 зүйлийг би саяын энэ ярьсан зүйлүүд дээр бас тусгаж оруулаад баталъя гэсэн ийм саналууд байна.

Л.Мөнхбаясгалан гишүүн санал хэлье.

**Л.Мөнхбаясгалан:** С.Ганбаатар гишүүний саналуудыг. Та санал гаргаж байна шүү дээ. Одоо энэ дээр жишээ нь. Манай оруулж ирсэн тогтоолын төсөл дээр. Энэ бол 13 гишүүнээс 9 гишүүний саналаар орж ирсэн тогтоолын төсөл.

Тэгэхээр нэг бүрчлэн санал хураалгаад явчихъя. Одоо шууд найруулгын засвар хийх нь юм уу, хийхгүй юм уу. Шууд нэг бүрчлэн санал хураагаад батлаад явчих уу?

**С.Ганбаатар:** Тэгвэл 5 санал байгаа. Саяын саналуудыг.

---

<sup>4</sup> EPCC буюу Инженерчлэл, Худалдан авалт, Барилга, Ашиглалт нь хувийн хэвшлийнхний гүйцэтгэсэн томоохон хэмжээний буюу нарийн төвөгтэй дэд бүтцийн төслүүдийн барилгын ажилтай холбоотой гэрээ. EPCC-ийн дагуу гүйцэтгэгч нь барилга байгууламжийг тодорхой хугацаанд, баталгаат үнээр гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх үүрэгтэй бөгөөд хүлээлтийн түвшинд хүрэх ёстой. Үүнийг хийхгүй бол гүйцэтгэгч нь мөнгөний албадлагын хариуцлагыг хүлээхэд хүргэж болзошгүй байдаг.

Тэгээд тогтоолын төсөлд доорх агуулгатай дараах заалтыг нэмж тусгах.

Олон улсад нефть боловсруулах үйлдвэрийн төсөлд тавигддаг шаардлагын дагуу эдийн засгийн үр ашиг, техник технологи, байгаль орчны хувьд боломжтой гэдгийг техник, эдийн засгийн үндэслэлээр баталгаажуулсан байх арга хэмжээг авах.

Энэ саналыг дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү. /алх цохив/

Ингээд дараагийн саналаа хэлье. 13.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн техникийн зураг төсөл, үйлдвэрийг барьж байгуулах зардлын төсөв, барилга угсралтын ажлын график төлөвлөгөөг олон улсын стандартын дагуу үйлдвэрийн барилга, угсралтын ажил эхлэхээс өмнө бүрэн боловсруулж, баталгаажуулсан байх арга хэмжээг авах.

Ингээд санал хураалт. /алх цохив/

Ингээд санал гаргасан С.Ганбаатар протоколд тусгаж байгаа. 13.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Техникийн зураг төслийн үйлдвэрийн технологийн тоног төхөөрөмж нийлүүлэх, үйлдвэрийг барьж байгуулах төсөв, барилга угсралтын ажлын графикайн дагуу барилгын ерөнхий гүйцэтгэгчтэй үйлдвэрлэлийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх, түлхүүр гардуулах нөхцөлөөр байгуулсан ЕРСС гэрээ хийж баталгаажуулсан байх арга хэмжээг авах.

Санал гаргасан Сайнхүүгийн Ганбаатар. /алх цохив/

13.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

Үйлдвэрийг түүхий тос цэвэр, усны нөөцөөр хэрхэн баталгаатай хангахтай холбогдсон дүгнэлт. Хэрэв дээрх хоёр нөөцөөр хангах боломжгүй бол хэрхэн шийдэх тухайгаа Улсын Их Хуралд танилцуулах арга хэмжээг авах.

Л.Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

**Л.Мөнхбаясгалан:** Тийм.

Тэгэхээр одоо яг энэ юуг хэлэлцээд байгаа нь бүр ойлгомжгүй болчихлоо. Энэ ажлын хэсгээс гаргасан тогтоолын төсөл дээр Та санал болгож байна. Тийм үү? Оруулах нэмэлтүүдээ санал болгоод байна. Тийм ээ.



Тэгэхээр ТЭЗҮ-тэй холбоотой байх магадлалтай саналууд яваад байдаг. Бид ТЭЗҮ-тэй танилцаагүй байгаа.

Тэгэхээр санал өгөхөд аягүй ээдрээтэй. Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал. Саяын таны дотоодын эх үүсвэрээс түүхий тос, ус хоёр чинь их чухал байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүн дээрээ усаа нэмээд л орчих юм биш үү? Тийм. 5 дээр. 1.5 дээр тайлбар аваад яваад байх юм уу?

**С.Ганбаатар:** Тийм. За яах вэ. Би дэгээрээ зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүн нь яах вэ тайлбар хэлэх ёстой ч гэсэндээ ажлын хэсгийн нөхдүүдээ бас би хүндэтгэж байна.

Тэгээд энэ асуудлуудыг ингэж ярьж байгаа нь байна шүү дээ ажлын хэсэг зөндөө их ажилласан. Тэгээд яах вэ, энэ саналуудыг. Энэ заавал протоколд орно. Маргааш тэгээд хүчиндээд ч байна уу, хүчлэхгүй хэлж байгаад ч байна уу баталгаажих байх. Монголын ард түмний өмнө бидний энэ шийдвэр түүхэн хариуцлага.

Тэгэхээр би заавал протоколд тусгаж ингэж ярих нь миний ажил.

Ингээд үйлдвэрийн түүхий тос, цэвэр усны нөөцөөр хэрхэн баталгаатай хангахтай холбогдсон дүгнэлт гэж ТЭЗҮ-г үзээгүй учраас би үүнийг харин хэлж байна шүү дээ. Энэ дүгнэлтүүдээ өгөөч ээ гэж байна шүү дээ. Энэ арга хэмжээгээ Их Хурал одоо нэгэнт хүчиндээд явсан ч гэсэндээ дараа нь энэ хаврын чуулганаас өмнө яаралтай өгөөрэй л гэж арга хэмжээг ав гэж өгч байгаа юм.

Тэгээд холбогдох дүгнэлт. Хэрэв дээрх хоёр нөхцөлөөр хангах боломжгүй бол гэж. Мэдээж боломжгүй. Боломжгүй бол хэрхэн шийдэх тухайгаа Улсын Их Хуралд танилцуулах ёстой гэж би хэлж байгаа. Уг нь би монголоор ярьж байгаа.

Тэгэхээр их ойлгомжгүй ярьсан байж магадгүй. Хамаагүй ээ. Энэ дээр Та бүхэн маань гишүүд саналаа хэлнэ үү. Санал гаргасан Сайнхүү овогтой Ганбаатар. /алх цохив/

Ингээд 33.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

Энэ үйлдвэр нь өөрийн ашгаас нийт хөрөнгө оруулалтаа нөхөн төлөх баталгаат тооцоог Улсын Их Хуралд ирүүлсэн байх.



Би ТЭЗҮ үзээгүй учраас ингэж “та таа тунгаа”-даж байгаа юм шүү дээ. Тийм баталгаат тооцоо байдаг бол тэрийгээ Улсын Их Хуралд ирүүлээч ээ. Энэ арга хэмжээгээ яаралтай авна уу. Хаврын чуулганаас өмнө ирүүлээрэй.

Үгүй ээ, би их ойлгомжтой л юм яриад байгаа шүү дээ.

Ингээд энэ саналыг дэмжиж санал хураая. /алх цохив/

33.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

Ингээд тэр найруулгын нэг санал. Одоо хурал удирдаж байгаагийн хувьд хэлэхгүй бол болохгүй санагдаад байх юм. Та нар маань ойлгоорой.

Тогтоолын төслийн зардлын хяналтыг сайжруулах зорилгоор Монгол Улсын өндөр түвшний мэргэжилтнүүдийг баг томилж. Гомбын Ганбаатар гишүүн бол “олон улс” гэж оруулсан шүү. Тэр нь ч ороогүй байх шиг байна.

Бүгд Найрамдах Энэтхэг Улс болон бусад улсад хэрэгжиж байгаа зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ажилд хяналт тавьж оролцуулах гэж. Энэтхэг гэж заавал ингэж бичих нь Монгол төрийн яг хэл найруулга нь. Би үүнийг хэлнэ гэж байгаад мартчихсан байна шүү. Тэрийгээ бодолцоорой.

Энэтхэгт хэрэгжиж байгаа проект дээр бид зураг төслийг нь хянах гээд байгаа юм шиг болчхоод байна шүү дээ. Энэ чинь.

Тэгэхээр найруулгыг нь Та нар бодолцоорой. Тэгэхдээ яах вэ, үүнийг би санал гаргаад хэрэггүй байх. Та нар санал гаргах юм уу, үгүй юу? Энэтхэг гэж. Эмзэг шүү наадуул чинь бас.

Ж.Золжаргал гишүүний микрофоныг өгье. Та микрофондоо хэлчих. Дараа нь.

**Ж.Золжаргал:** Тогтоолын төслийн 1.1 дээрх найруулга дээр редакцын засвар оруулах саналтай байна.

Төслийн зардлын хяналтыг сайжруулах зорилгоор Монгол Улсын өндөр түвшний мэргэжлүүдээс бүрдсэн баг томилж, Бүгд Найрамдах Энэтхэг Улс болон бусад улсад хэрэгжиж байгаа зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ажилд хяналт тавьж оролцуулах гэдгийг төслийн зардлын хяналтыг сайжруулах зорилгоор үндэсний болон олон улсын хараат бус, өндөр түвшний мэргэжилтнүүдээс бүрдсэн баг томилж, төслийн хэрэгжилттэй холбоотой газруудад.

Тийм. Төслийн хэрэгжилттэй холбоотой дотоодод болон хилийн чанад дахь байрлалд гэчихье дээ. Байрлалд хэрэгжүүлж байгаа зураг төсөл, худалдан

авалт, барилга угсралтын ажилд хяналт тавьж оролцуулах. Ийм саналтай байна. Бичээд өгчихье.

**С.Ганбаатар:** Саяын Ж.Золжаргал гишүүний саналыг дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү.

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Энхтуяа гишүүн бас протоколд тусгасан. Дэмжиж байгаа гэж.

Ингээд өөр саналууд. Тийм үү. Редакц юм уу, зарчмын зөрүүтэй санал юм уу гэдгээ тайлбар өгөх хүн байна уу? Хуулийн хэлтсээс байгаа юу? Б.Тулга сайд саналаа тайлбарлая.

**Б.Тулга:** Би ийм санал гаргах гэсэн юм. Түрүүн зарчмын зөрүүтэй санал гээд минийх дээр чинь аваачаад явуулчихсан.

Тэгэхээр би редакцын засвар л оруулж байгаа шүү дээ. 38 сар. Нөгөөдөх нь 2028 оны 1 гэдэг чинь бас л ялгаагүй 37, 38. Гэхдээ тэгээд энэ Их Хурлын процесс яаж явахыг нь мэдэхгүй байна.

Тийм учраас одоо юу гэдэг юм, дахиад нөгөө гэрээтэй зөрчилдөхгүйгээр уялдуулаад л тэр гэрээн дээр зааснаар гарын үсэг зурснаас хойш 38 сар гээд. Тэр улирал гэдгийг л 38 сар гэдгээр редакц л оруулъя гэж байгаа юм.

Тэгэхээр редакцын томъёоллоор санал хураалгаж өгөхийг хуралдаан даргалагчаас хүсэж байна. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Б.Тулга гишүүний саналыг. Найруулгын санал юм байна шүү дээ. Тийм ээ. Найруулгын саналаар. Энэ ажлын хэсгийн оруулж ирсэн томъёоллоор байхгүй. Өөрчилъе гэсэн санаа байна шүү дээ. Тийм ээ. Оруулъя гэж байна.

Дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү. Б.Тулга сайдын микрофоныг нээж өгье.

**Б.Тулга:** Тэгэхээр өмнө хураагдсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол гэдэг дээр буруу ойлголт би яасан учраас буруу хийсэн байна.

Тийм учраас миний энэ алдааг яагаад. Энэ саналыг хүчингүй болгоод редакцын гэдгээр хураалгаж өгнө үү гэж хүсэж байна.

**С.Ганбаатар:** Ингээд Б.Тулга гишүүний саналын томъёолол. Санал хураалт.

Ингээд 60.0 хувиар хүчингүй болгох санал дэмжигдлээ.

Ингээд Б.Тулга гишүүний саналын томьёолол. Төслийн 2 дахь дэд заалтын 2028 оны нэгдүгээр улиралд гэснийг.

ЕРС-4 гээд нохой заалт л даа. Одоо тэгсэнд орвол тэр хугацаатайгаа байхгүй бол. ЕРС болоод л явчихвал нохой болдог шүү. ЕРС-4 гэрээнд туссан томьёололтой ямар нэгэн юмтай л холиод л эхэлбэл тэгээд л цаадуул чинь авьяасаа үзүүлдэг юм даа.

ЕРС-4 гэрээнд туссан томьёололтой уялдуулсан гэрээ зурагласнаас хойш 38 сарын дотор багтааж гэж өөрчлөх гэсэн ийм саналын томьёололыг. Найруулгын саналыг дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү. Санал хураалт. /алх цохив/

33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Ингээд үндсэндээ тэр сар, оноотойгоо л үлдэх шиг боллоо.

Ингээд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Саналын томьёолол 60.0 хувиар дэмжигдлээ.

Далайн Батбаяр гишүүн дэмжиж санал өгсөн. Протоколд тусгая.

Ингээд тогтоолын төсөл батлагдлаа. Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүддээ баярлалаа. Өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 53 минут үргэлжилж, 18 цаг 54 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**